


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠷᠭᠠᠭ



БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ



НЭГ ЦЭГИЙН МЭДЭЭ

# ONE STOP

Солонгост суугаа Монголчуудад зориулан үйлчилгээ гаргаж буй анхны сэтгүүл 2021 IV улирал

БНСУ дахь  
ХНХҮТ-ийн дарга  
Д.Баярмандах:

ХНХЯ-НЫ ХАРЬЯА БНСУ ДАХЬ  
ХНХҮТ-ИЙН 10 ЖИЛИЙН ОЙ БОЛ  
ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭТ  
ИРГЭД, ДААТГУУЛАГЧИД,  
БНСУ-Д АМЬДАРЧ БУЙ  
МОНГОЛЧУУДЫН ХУВЬД  
ЧУХАЛ ТЭМДЭГЛЭЛТ  
ӨДӨР ЮМ

Засгийн газрын хэрэгжүүлэгч  
агентлаг Хөдөлмөр, халамжийн  
үйлчилгээний ерөнхий газрын  
дарга Л.Дашдэмбэрэл:

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ИРГЭДЭЭ ИЛГЭЭХ  
БОЛОН ХҮЛЭЭН АВАХ ТАЛААР ХОЁР ТАЛ  
БАГАГҮЙ ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАН  
АЖИЛЛАЖ БАЙНА

Сөүлийн Жүнбу  
цагдаагийн газрын  
гадаад иргэд хариуцсан  
байцаагч Чой Дү Мин:

ХУУЛЬ БУСААР ОРШИН  
СУУГЧИД ГЭМТ ХЭРГИЙН  
ХОХИРОГЧ БОЛСОН БОЛ  
ЦАГДААД ГОМДОЛ  
ГАРГАХ ЭРХТЭЙ



БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ



АРВАН ЖИЛИЙН  
ОНЦЛОХ ҮЙЛ  
ЯВДЛУУД

“Nice Mongolia World”  
ХК-ийн захирал  
Д.Даваабаатар:

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР  
ИРЭЭД АЖЛЫН ХӨЛСӨӨ  
ЦУГЛУУЛЖ БИЗНЕС  
ҮҮСГЭН БАЙГУУЛААД  
ХИЧЭЭЖ, ЗҮТГЭЖ ЯВНА

[www.seoulcenter.mlsp.gov.mn](http://www.seoulcenter.mlsp.gov.mn)





1-р Салбар

010-9911-4923

ЖИНЖУ, ЧАНВОН, ГИМХЭ, ЯНСАН, СОЧАН КОЖЭДҮ,  
МИРЯАН, ЧАНЁН, БУСАН, УЛСУН, ГҮМИ, ДЭГҮ,  
ЁОНЧОН, ГЁЛСАН, ПУХАН

2-р Салбар

010-9911-3519

ГУМИ, ЧҮНЖУ, ВОНЖУ

3-р Салбар

010-9911-4497

ЧОНЖУ, СЭЖУН, ЖУЧИВОН, ЖИНПЁОН, ЖИНЧОН

4-р Салбар

010-9911-3995

ИЛСАН, ИНЧЕОН, БҮЧОН, ГИМПҮ, МАСУН, ГУ-ЯН, ПАЖУ

5-р Салбар

010-9911-4995

СӨҮЛ, НАМЬЯНЖУ, АНСАН, СУВОН, ХУАСОН

6-р Салбар

010-9911-6027

ТЭЖОН, НУНСАН

7-р Салбар

010-9911-4993

ЮУНЫН, СУВОН, ХУАСОН, ПЁНТЭГ

8-р Салбар

010-9911-9749

СУВОН ШИГДАН, ПАРАН

9-р Салбар

010-9911-7551

ЧОНЖУ, ГҮПСАН, ИГСАН, ИМШИЛ, ЖИНАН

10-р Салбар

010-9911-4165

ГАНВОНДУ, ИЧЁОН, ЖИЖИГ ГУАНЖУ

11-р Салбар

010-9911-9067

ҮҮЖИН-БҮ, ДҮНДҮ-ЧОН, ЯАНЖУ, ПУЧОН СҮЛД  
ХООЛНЫ ГАЗАР

12-р Салбар

010-9911-8128

СӨҮЛ, НАМЬЯНЖУ

13-р Салбар

010-8686-0808

ИНЧЕОН /ТӨВ САЛБАР/

14-р Салбар

010-9911-4168

ЖЭЖҮ

15-р Салбар

010-9911-3095

МОГПУ

16-р Салбар

010-9911-6209

СӨҮЛ, "EXIT" БАТАЛГААТ ОРЧУУЛГА.

17-р Салбар

010-9911-4131

СӨҮЛ, "AIR NET WORK" БИЛЕТТИЙН КАСС

ТӨВ САЛБАР:

인천시 연수구 옥련동 194-162

# ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ЗУУЧ

NICE MONGOLIA WORLD CO.,LTD



- **КОНТЕЙНЕР ТЭЭВЭРЛЭЛТ**  
/ЭНГИЙН БОЛОН ХӨРГҮҮРТЭЙ /40 ТОНН, 20 ТОНН
- **КОНТЕЙНЕР ТҮРЭЭС 20 ТОНН**
- **МАШИНЫ ХУДАЛДАА**
- **МАШИНЫ ХАСАЛТ**
- **ХҮНД МЕХАНИЗМ, АВТО МАШИН ТЭЭВЭР**
- **БҮХ ТӨРЛИЙН БИЗНЕС БАРАА ТЭЭВЭР**
- **БАРИЛГЫН БҮХ ТӨРЛИЙН БАРАА**
- **БҮХ ТӨРЛИЙН ЗАДГАЙ ТЭЭВЭРЛЭЛТ**



СОЛОНГОС ДАХЬ УТАС:



Карго лавлах: **010-8686-0808**

Тээвэр лавлах: **010-9911-6447**



МОНГОЛ ДАХЬ УТАС:



Карго лавлах: **8999-7878**

Тээвэр лавлах: **8008-9777**



# КОНТЕНТ

4

**Редакцийн зурвас:**

Солонгост суугаа Монгол хүн бүрт хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын чиглэлээр төрийн үйлчилгээ хүрч эхэлсний 10 жил

8-23

Арван жилийн онцлох үйл явдлууд



26-27

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л. Дашдэмбэрэл: Хүлээгдэж буй иргэдээ илгээх болон хүлээн авах талаар хоёр тал багагүй хүчин чармайлт гарган ажиллаж байна.



32-33



Сити их сургууль



41-43, 45  
48-49



**Дугаарын зочин:** “Nice Mongolia World” ХК-ийн Ерөнхий захирал Д. Даваабаатар: Хөдөлмөрийн гэрээгээр ирээд ажлын хөлсөө цуглуулж бизнес үүсгэн байгуулаад хичээж, зүтгэж явна

54-55



**Тэд Монголын тухай:** БНСУ-ын Хууль зүйн яамны харьяа Хуасон хотын гадаад иргэдийг түр хамгаалах төвийн дарга Кил Кан Мүг: Тал нутагт эгшиглэх морин хуурын аялгуу

5-6



**Мэндчилгээ:** БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга Д. Баярмандах: ХНХЯ-ны харьяа БНСУ дахь ХНХҮТ-ийн 10 жилийн ой бол хөдөлмөрийн гэрээт иргэд, даатгуулагчид, БНСУ-д амьдарч буй монголчуудын хувьд чухал тэмдэглэлт өдөр юм

24



Монгол иргэд НАМ ГИ СЭ эмнэлгээр хөнгөлөлттэй үйлчлүүлж байна

30



**Мэдээ:** БНСУ-ын Засгийн газраас шийд гарвал хөдөлмөрийн гэрээт иргэдийг 2019, 2020, 2021 онд бүртгүүлсэн дарааллаар хүлээж авна.

34, 36

Хууль эрх зүйн

**мэдээлэл:**

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ямар иргэд хамрагдах вэ?



50-51

“Нутгийн буян групп” ХХК. Таны тав тухтай, амар тайван амьдрах “Аз жаргалын төгөл” – ийг бид танд



56-57



Сөүлийн Жүнбу цагдаагийн газрын гадаад иргэд хариуцсан байцаагч Чой Дү Мин: Хууль бусаар оршин суугчид гэмт хэргийн хохирогч болсон бол цагдаад гомдол гаргах эрхтэй

7




**Мэндчилгээ:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А. Ариунзаяа: Та бүхэн монгол хүнээ гэсэн төрийн бодлогыг хилийн чанадад өргөж яваа бахархам үйлстэй хамт олон

25



**Мэргэжилтэн зөвлөж байна:** ХНХҮТ-ийн мэргэжилтэн Б. Ганцэцэг: Олгогдоогүй цалингийн асуудал гэж юу вэ?

31



**Мэдээ:** БНСУ-ын “Глобал лидер ассет” ХХК-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

37, 40



**Мэргэжилтэн зөвлөж байна:** ХНХҮТ-ийн мэргэжилтэн К. Зулзаяа:

Та нийгмийн даатгалаа төлж байгаад хөдөлмөрийн чадвараа алдсан бол тэтгэмж авах боломжтой

52-53

**Амралт чөлөөт цаг, гэр бүл:**

Цээжлээд аваарай, Үгийн таавар.

Эхийн хэвлий дэх боловсрол буюу ургийн боловсролын тухай



58-59

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зөвлөгөө





## Редакцийн зурвас

### СОЛОНГОСТ СУУГАА МОНГОЛ ХҮН БҮРТ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРЧ ЭХЭЛСНИЙ 10 ЖИЛ

Солонгост хорио цээрийн дэглэм суларч байна. БНСУ 11 дүгээр сарын 1–ээс эхлэн “Коронавирустэй зэрэгцэн амьдрах” горимд орлоо. Дархлаажуулалтын үзүүлэлт өндөр гарч байгаа тул ийнхүү хэвийн амьдралд шилжих 3 үе шат бүхий ажлыг хэрэгжүүлж байна. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв ч цар тахлын үеийн ажлын горимоор үйл ажиллагаагаа явуулж байгаад мөн л хорио цээрийн үеийн журмаа султган явуулын үйлчилгээгээ иргэдэд хүргэж эхэллээ. Төвийн мэргэжилтнүүд, тэдний ар гэрийнхэн вакцинд бүрэн хамрагдаж дууссан өдрөөс эхлэн ердийн горимоор ажиллах шийд гараад байна. Цар тахлын хүнд, урт, хэцүү үед зохион байгуулалт сайтай, эрсдэл багатай, хүнээ бодсон зөв чиглэл, шийдвэрүүдээр байгууллага авч гарсан төвийн удирдлагадаа хамт олныхоо өмнөөс талархлаа илэрхийлэх цаг нь болжээ. Төвийн ажилтнууд, тэдний гэр бүл болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэд, Солонгост суугаа монголчуудынхаа эрүүл мэндэд санаа тавьж, байнга анхааруулж, сэрэмжлүүлэн, өөрийн биеэр шууд лайв хийн нөхцөл байдлыг мэдээлж, зөвлөж байсан, уулзалт, ажлаар явах бүртээ

гэрээгээр ажиллагч иргэддээ маск, ариутгалын бодис өгч, өвдсөн иргэдэд анхаарч, Монгол Улс руугаа олон мянган маск илгээх ажлыг хэрэгжүүлсэн ХНХҮТ–ийн дарга Д.Баярмандах танд их баярлалаа. ХНХЯ–ны харьяа БНСУ дахь ХНХҮТ зөв удирдлага, зохион байгуулалтын ачаар цар тахлын өдрүүдэд ажил үйлчилгээгээ нэг ч өдөр тасалдуулаагүй хөдөлмөрийн гэрээт иргэд, энд амьдран суугаа бусад иргэдэд үйлчилж ирснээс гадна Монголоос гэрээт иргэдийг авах асуудлаар шат шатны байгууллагуудтай харилцан холбоотой ажиллаж тодорхой үр дүнд хүрч байна. БНСУ–д хэвийн амьдралд шилжих 3 үе шат бүхий арга хэмжээ хэрэгжиж эхэлснээр Засгийн газраас гадаадаас ажиллах хүч авах асуудлаар нааштай шийд гарч илгээгч 16 орноос гэрээт иргэдийг авах ажиллагаа эхэлж байна. Энэ мэтчилэн Солонгос улсад цагийн байдал наашилж байгаа хэдий ч Монгол Улсын дотоодын коронагийн тархалт, өвчлөлийн нөхцөл байдал хоёр улсын хооронд иргэдийн харилцан зорчих асуудалд нөлөөлж магадгүй тул улс оронд минь ч цар тахал хумигдаасай хэмээн хүснэм.

“Нэг цэг” сэтгүүлийн энэ дугаар БНСУ дахь Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын үйлчилгээний төв үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан хэвлэгдэж байгаагаараа онцлог боллоо. Төвийн дарга Д.Баярмандах, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ХНХ–ын сайд А.Ариунзаяа нар 10 жилийн ойн баярт зориулан мэндчилгээ дэвшүүлэв. Манай хамт олон 10 жилийн онцлох үйл явдлуудаа нэрлэж, түүхэн хугацаан дахь статистик мэдээллүүдэд нэгтгэн нийтэллээ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл хөдөлмөрийн гэрээт иргэдийн асуудлаар тодорхой мэдээлэл бүхий ярилцлага өгсөнд талархаж байна.

Сэтгүүлийн нүүрээ бид E–9 визээр хөдөлмөрийн гэрээгээр анх ирээд БНСУ–д “Nice Mongolia” ХК байгуулан ажиллаж, 40 орчим монголчуудыг ажлын байраар хангаж буй өсөж яваа залуу бизнесмэн, уйгагүй хөдөлмөрч залуу Д.Даваабаатарын зургаар чимж түүний “Монгол хүний хөгжил” подкастад өгсөн ярилцлагыг хүргэж байна. Түүнчлэн та бүхэн энэ дугаараас Солонгосын Жүнбү Цагдаагийн газрын Гадаад иргэдийг хариуцсан Чой Дү Мин байцаагчтай

хийсэн сэрэмжлүүлэг яриа, тус улсын Хууль зүйн яамны харьяа Хуасон хотын гадаад иргэдийг түр хамгаалах төвийн дарга Кил Кан Мүгийн монгол морин хуурын гайхамшигийг бичсэн сонирхолтой нийтлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын болон олгогдоогүй цалин хөлсний талаарх зөвлөгөө, Монгол Улсын нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл, хууль эрхзүйн ойлголтууд, үйлдвэрийн осол гэмтлийн сэрэмжлүүлэг, Солонгост амьдран суугаа монгол иргэдэд хэрэгтэй зар сурталчилгаа, дэмжигч байгууллагуудын мэдээлэл зэргийг уншаарай!

Сэтгүүлийн энэ дугаарт Тасгийн дарга Я.Энхбаясгалан, Л.Доржсүрэн, мэргэжилтэн Ю.Сумъяажав, Я.Гармаа, Д.Үнэнбат, Э.Энхбилэг, Ч.Энхжаргал, А.Лхагвамаа, П.Дарханбаатар, Ц.Мөнхцацрал, Б.Ганцэцэг, Х.Золгэрэл, М.Гантулга, К.Зулзаяа, М.Лхагвасүрэн, Л.Аззаяа, О.Даваажав нар мэдээ мэдээллүүдийг бэлтгэж, Ж.Жаргалсайхан редакторлан ажиллалаа. ХНХЯ–ны харьяа БНСУ дахь ХНХҮТ–ийн 10 жилийн түүхэн үйл ажиллагааны онцлог мэдээ мэдээллүүд бүхий “Нэг цэг” сэтгүүлийнхээ шинэхэн дугаарыг хүлээж авна уу?





## Мэндчилгээ

Хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцоо”-ны дагуу “Ажиллах хүч илгээх санамж бичиг”-ийн хүрээнд тус улсад E-9 визээр хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт гэрээт иргэд болон хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллаж байсан мянга мянган залуучууд, Солонгост оршин суугаа нийт монголчууд, эдгээр иргэдэд хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллахад дэмжлэг үзүүлж, хууль ёсны эрх ашгийг нь хамгаалан ажиллаж байгаа ХНХҮТ-ийн хамт олон, өмнө нь ажиллаж байсан үе үеийн удирдлагууд болон мэргэжилтнүүд, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, бидэнтэй хамтран ажилладаг БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэг эрхлэх газар, Үндэсний тэтгэврийн албаны удирдлага, хамт олонд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв байгуулагдсаны 10 жилийн ойн мэндийг хүргэн мэндчилж байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор одоогоос 10 жилийн өмнө буюу 2011 оны 11 сарын 17-ны өдөр БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв албан ёсоор нээлтээ хийж, нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн



харилцааны асуудлаар Солонгост оршин суугаа иргэддээ төрийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн түүхтэй. Үүнээс өмнө нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцааны үйлчилгээ нь тус тусдаа явж ирсэн ба 2004 оноос өнөөг хүртэл БНСУ-д 29 439 иргэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллажээ.

Иргэддээ нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцааны асуудлаар төрийн үйлчилгээ үзүүлж, иргэдийнхээ өмнө тулгамдсан олон асуудлыг хоёр орны хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж, тэдний хөдөлмөрлөх эрхийг хангуулан, амь нас эрүүл мэндийн төлөө ажилласан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн өнгөрсөн 10 жилийн ажлуудаас тоогоор товч илэрхийлбэл, нийт 42 159 иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн 15.138.540.682 төгрөгийг иргэдэд олгуулж, 23 861 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд, 1 753 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулан Нийгмийн даатгалын санд нийт 31.400.000.000 төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлсэн байна. Үүнээс гадна 2007-2020 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд манай улсаас хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан 15 995 иргэн БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас 26.184.000.000 воны нэг удаагийн буцаан олголтыг авчээ. 2004 оноос 2021 оны 9 сарын хооронд Үйлдвэрийн ослын даатгалын газраас үйлдвэрийн осолд орсон иргэдэд нөхөн олговор,



ажилгүйдлийн тэтгэмж, эмчилгээний зардалд 42.491.029.510 вон буюу 106.227.573.775 төгрөгийг олгожээ. Энэ 10 жилийн хугацаанд ХНХҮТ-ийн ажил үйлчилгээгээр дамжин иргэдэд болон Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн мөнгөн дүн нийтдээ 66.946.445.783 вон буюу 152.766.144.457 /Нэг зуун тавин хоёр тэрбум долоон зуун жаран зургаан сая нэг зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун тавин долоо/ төгрөг болоод байна.

Ийм ч учраас ХНХЯ-ны харьяа БНСУ дахь ХНХҮТ байгуулагдсаны 10 жилийн ой бол энэ төвөөр үйлчлүүлж хуулийн дагуу эрхээ хамгаалуулж, авч чадаагүй цалин хөлс, гэнэт халагдсаны тэтгэмж, үйлдвэрийн ослын болон гэнэтийн ослын даатгалын мөнгөө олж авч, эрүүл

мэндийн үнэ төлбөргүй үйлчилгээ, эмнэлгийн хөнгөлөлт эдлэн хөдөлмөрийн харилцаанд тулгарсан олон асуудлаа шийдвэрлүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг авч байгаа хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч иргэд болон БНСУ-д оршин сууж, ажиллаж, амьдарч буй 40 гаруй мянган иргэд, тэдний гэр бүлийнхний хувьд чухал тэмдэглэлт өдөр юм.

10 жилийн ойтойгоо золгож буй ХНХҮТ-ийн хамт олондоо болон хөдөлмөрийн гэрээт иргэд, даатгуулагчид, Солонгос улсад амьдран сууж буй нийт монголчууддаа аз жаргал, хамгийн сайхан бүхнийг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе!

Та бүхний ажил үйлс амжилт, бүтээлээр арвин байх болтугай!

ХНХЯ-ны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын үйлчилгээний төвийн дарга



Д.БАЯРМАНДАХ





## Мэндчилгээ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд ажиллаж байсан болон одоо ажиллаж буй хамт олон, удирдлагууд мөн БНСУ-д сурч, ажиллаж, амьдарч буй монголчууд та бүхэндээ Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв байгуулагдсаны 10 жилийн ойн баярын мэндийг салбарынхаа хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа хүргэн мэндчилж байна.

Та бүхэн монгол хүнээ гэсэн төрийн бодлогыг хилийн чанадад өргөж яваа бахархам сайхан үйлстэй хамт олон. Эх орондоо байгаа хүмүүст төрийн үйлчилгээ үзүүлнэ гэдэг нэг хэрэг. Харин хүний нутагт аж төрж буй монгол ахан дүүстээ төрийн нэрийн өмнөөс үйлчилнэ, тэдний эрх ашгийг хамгаална, тусалж дэмжинэ гэдэг бас өөр хэрэг. Хууль ёсны үйлчилгээнээс гадна хүн ёсны харилцаа, эерэг хандлага, өөриймсөг сэтгэл та бүхний ажил үйлсэд багагүй жин дардаг нь талархам сайхан.

Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, боломжит үйлчилгээнүүдийг цахимд шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ



бодлого эхнээсээ богино хугацаанд хэрэгжиж чамлахааргүй үр дүнд хүрч байгааг төрийн үйлчилгээнд нэвтэрч буй цахим шинэчлэлүүдээс харж болно. Ялангуяа, хөдөлмөр эрхлэлт, халамж, нийгмийн даатгалын олон арван үйлчилгээг иргэд гэрээсээ, гар утаснаасаа авдаг болсон. Энэ шинэчлэлийг үргэлжлүүлэхэд, цаашид шинэ шийдлээр баяжуулж үр өгөөжийг нь гадаадад оршин суугаа монгол иргэддээ хүргэхэд та бүхний санаачилга, туршлага, үүрэг, оролцоо их гэдгийг онцлон хэлье.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн хамт олон та бүхэн монголчууддаа үйлчилгээ үзүүлэхээс гадна БНСУ-ын хөгжил, технологийн дэвшил, төрийн үйлчилгээний стандарт, давуу талуудыг олж харж, авч болох сайн туршлагуудыг шингээх, цаашлаад эх орондоо нутагшуулах чиглэлд санаа тавьж ажиллах нь ирэх он жилүүдийн ажил үйлсийн тань нэг хэсэг байна гэдэгт итгэлтэй байна. Та бүхний маань ажил амьдрал өөдлөн дэвжиж, үйлс зорилго тань өргөжин дэлгэрэхийг хүсэн ерөөе!

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд монгол хүндээ үзүүлсэн төрийн үйлчилгээ, тэдэнд тусалж дэмжсэн ажил үйлс, халуун сэтгэл тань эерэг сайхнаар эргэн хурах болтугай!

Монгол Улсын Засгийн газрын гишүүн,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

А.АРИУНЗАЯА

# АРВАН ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



10  
2011-2021  
ЖИЛИЙН ОЙ

## БНСУ-ЫН СӨҮЛ ХОТНОО “ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” АЛБАН ЁСООР НЭЭГДЛЭЭ



## БНСУ ДАХЬ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАГДАВ

Монгол Улсын Засгийн Газар, БНСУ-ын Засгийн Газар хооронд байгуулсан “Нийгмийн Хамгааллын Тухай Хэлэлцээр” нь 2007 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Ингэснээр хоёр орны иргэд нийгмийн даатгалын шимтгэлийг давхар төлөхөөс чөлөөлөгдөж, өөрөөр хэлбэл монгол ажилчид БНСУ-ын тэтгэврийн даатгалд цалингаасаа сар бүр 4,5 хувиар даатгалын шимтгэл төлж байсныг чөлөөлж өөрийн орны тэтгэврийн даатгалын санд сар бүр **40,000** воныг төлөхөөр болсон юм.

2011

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2011 оны 06 дугаар сарын А/82 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн БНСУ-д Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай 306 дугаар тогтоолын дагуу БНСУ-ын Сөүл хотноо “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг байгуулахаар шийдвэрлэн албан ёсны нээлтийг 2011 оны 11 дүгээр сарын 17-нд хийж үйл ажиллагаагаа эхлүүлэв. Нээлтэнд Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Гэрэл, НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга У.Бямбасүрэн, БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хөгжлийн газрын дэд ерөнхийлөгч Ким Нам Ил болон албаны төлөөлөгчид оролцлоо.

*Нэг цэгийн үйлчилгээний төв нь БНСУ-д ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэн бүрт хүрч ажиллах зорилготой бөгөөд тэдний хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, бүх талаар дэмжиж туслах үүрэгтэй үйлчилгээний байгууллага байхаар шийдвэрлэжээ.*

БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдэд нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ач холбогдлыг ухуулан таниулах, нийгмийн даатгалд хамруулах зорилгоор 2007 онд Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын “БНСУ дахь Нийгмийн даатгалын алба”-ыг анх 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр нээн ажиллуулсан бөгөөд уг алба нь 2009 оны 01-р сарын 26-ны өдрөөс эхлэн “БНСУ дахь Нийгмийн даатгалын төлөөлөгчийн газар” болон өргөжиж ахлах мэргэжилтэн 1, шимтгэл орлого хариуцсан мэргэжилтэн 4, туслах ажилтан 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.







**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ  
ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ /2007 оны 177 дугаар тогтоолыг/**

2011 оны 4 дүгээр сарын 13-ны  
өдөр

Улаанбаатар хот

**Дугаар 115**

**Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны хооронд 2011 оны 3 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан “БНСУ-д ажилчид илгээх тухай” харилцан ойлголцлын санамж бичигт Монгол Улсаас БНСУ-д ажиллах хүч илгээх ажлыг төрийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр заасантай холбогдуулан “Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай” Засгийн газрын 2007 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 36 дугаар тогтоол, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2007 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 177 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Гадаадад ажиллах хүч илгээх төв” ХХК-тай холбогдолтой асуудлыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд**

**С.БАТБОЛД**

**Нийгмийн хамгаалал,  
хөдөлмөрийн сайд**

**Т.ГАНДИ**



МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН  
ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.2, 24 дүгээр зүйлийн 2, 20 дугаар зүйлийн 5.10, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.1, 4.1.5, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын "Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу БНСУ-д ажилчид илгээх тухай" Харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.БНСУ-д ажиллах хүч илгээх асуудлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан гүйцэтгэх болсонтой холбогдуулан БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх ажлыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын БНСУ дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Д.Баярсайхан/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ч.Алтанхуяг/-т тус тус даалгасугай.

2.БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуяг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Баярсайхан нарт, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга У.Бямбасүрэнд даалгасугай.

САЙД



Т.ГАНДИ



# БНСУ-ЫН ЭЛЭГ СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГ, “ЭЛЭГ” САН, “АНАМ” ЭМНЭЛЭГ, “ВОН” ЭМНЭЛЭГТЭЙ ХАМТРАН МОНГОЛ ИРГЭДДЭЭ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЗЛЭГ, ОНОШЛОГОО ХИЙХ АЖЛЫГ УЛАМЖЛАЛ БОЛГОЛОО

2013 оны 10 дугаар сарын 6-ны өдөр БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төвөөс Солонгосын элэг судлалын нийгэмлэг, “Элэг” сантай хамтран Солонгос улсад ажиллаж амьдарч буй монгол иргэддээ зориулан элэгний үнэгүй үзлэг, оношлогоог явууллаа. Үүнд, Элэг судлалын нийгэмлэгийн гишүүн Самсунг, Хөндэй Асан, Сөүл, Кореа дээд сургуулийн эмнэлгүүдэд ажиллаж буй 10 эмч болон нийгэмлэгийн сайн дурын 20-иод ажилтан оролцжээ.

# 2013



2019 оны 7–11 дүгээр сард сар бүрийн эхний долоо хоногийн хагас сайн өдрүүдэд Кореа их сургуулийн “Анам” эмнэлгийн эмч нартай хамтран үнэгүй эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж



Дотрын эмчийн үзлэгт	132
Сахарын шинжилгээнд	60
Биеийн оношлогоо	40
Ясны сийрэгжилтийн оношлогоо	40
Шээсний шинжилгээнд	94
Зүү эмчилгээнд	39
Зүрхний бичлэг	17
Шүдний эмчийн үзлэгт	50
Дүрс оношлогооны эхо үзлэгт	66
Цусны шинжилгээнд	112
Үнэгүй эм олгоход	18

иргэнийг хамруулан давхардсан тоогоор **668** иргэнд эрүүл мэндийн үнэгүй үйлчилгээг үзүүлж, нийт дүнгээр **164,147,034** воны үзлэг, эмчилгээ, оношлогоог үнэ төлбөргүйгээр хийж үйлчилжээ.



2019 оноос эхлэн Кёнги аймгийн Өжинбү хотын гэмтэл, нуруу нугасны ВОН эмнэлэгтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсны үр дүнд манай төвөөр дамжин үзүүлж буй хөдөлмөрийн гэрээт ажилчид болон БНСУ-д оршин суух үнэмлэхтэй иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, оношлогоо, эмчилгээ хийж байгаа бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 298 иргэнд 28,502,312 воны үзлэг эмчилгээг үнэ төлбөргүйгээр үзүүлсэн дүн гарчээ.



# 2014



## “ХАРИУЦЛАГАТАЙ ДААТГУУЛАГЧ” АРГА ХЭМЖЭЭГ ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

БНСУ дахь Нийгмийн даатгалын алба үүсгэн байгуулагдсанаасаа хойш даатгалаа тасралтгүй төлж байгаа даатгуулагчдаа урамшуулах, бусад даатгуулагчдад үлгэр дуурайлал болгох зорилгоор 2014 онд анх “Хариуцлагатай даатгуулагч” шалгаруулан гарын бэлэг, өргөмжлөл гардуулжээ. Үүнээс хойш жил бүр 1–2 удаа хариуцлагатай даатгуулагчдаа урамшуулах ажиллагаа уламжлал болон зохион байгуулагдаж байна.



## МОНГОЛ ИРГЭДЭЭ ГЭМТ ХЭРГЭЭС УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ЦАГДААГИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор монгол иргэд олноор төвлөрсөн Түндэмүн, Чүнгү, Чүнну дүүргүүдээр сайн дурын эргүүл хийж, сургалт, зөвлөгөө өгөхөөр тус санамж бичигт тусгажээ. Энэ ажлын хүрээнд:



БНСУ-д ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн дунд гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа учир БНСУ-ын Жүнбү Цагдаагийн газартай хамтран ажиллах санамж бичгийг 2018 онд байгуулав. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалт зохион байгуулах ажлын хүрээнд иргэдээ



# 2018

2018 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Жүнбү Цагдаагийн газрын ахлах ажилтнууд төвийн байранд ирж уулзалт зохион байгуулав.

Сар бүрийн пүрэв гарагт монгол иргэд олноор төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг Түндэмүн дүүргийн бүс нутгаар сайн дурын эргүүлийн ажлыг цагдаагийн хэсэгтэй хамтран явуулж, иргэдээ гэмт хэрэгт холбогдох, халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Эдгээр ажлын үр дүнд 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдөр болсон БНСУ болон Монгол Улсын Гадаад харилцааны яам хоорондын консулын зөвлөлдөх уулзалтаар Монгол Улсын иргэд гэмт хэрэгт холбогдох явдал их гарч байгаа боловч сүүлийн 2 жилийн статистик мэдээллээс харахад гэмт хэрэгт холбогдсон иргэдийн тоо **9,7%**-иар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна гэж дүгнэсэн билээ

2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Жүнбү Цагдаагийн газар, Чүнгү дүүрэг, Түндэмүн дүүрэг, Өлжыру дүүргийн Цагдаагийн хэсгийн дарга нарын уулзалтаар ХНХҮТ болон Жүнбү Цагдаагийн газартай хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” ажлын хүрээнд 30 хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын эргүүл хийх 6 баг байгуулан ажиллахаар санамж бичиг байгуулжээ.

2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Чүнгү дүүргийн Цагдаагийн хэсгийн дарга хүрэлцэн ирж хамтран ажиллах төлөвлөгөөн дээр харилцан ярилцаж тохиролцлоо.



## МОНГОЛ, СОЛОНГОС ИРГЭД ТЭТГЭВРИЙН ДААТГАЛААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХУГАЦААГ СУНГАВ



2018 оны 10 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд Монгол Улсын НДЕГ болон БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны төлөөлөгчид хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор БНСУ-ын Сөүл хотноо уулзалт хийв. Тус уулзалтанд Монгол Улсын НДЕГ-ын дарга Д.Зоригт, БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Олон улсын хамтын ажиллагааны төвийн дарга Ким Жон Хү тэргүүтэй хоёр улсын төлөөлөгчид оролцов.

Уулзалтаар Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал солилцон харилцан зөвшилцөж, хэлэлцээрийн зарим заалтад өөрчлөлт оруулах, цаашид хэлэлцээрийг өөрчлөх, хамтран ажиллах хэд хэдэн асуудал дээр үр дүнтэй тохиролцоонд хүрч, протоколд гарын үсэг зуржээ. Ингэснээр хоёр орны иргэд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөөс харилцан чөлөөлөгдөх хугацааг 5 жил гэж заасан байсныг 9 жил болгон өөрчилсөн байна.





# 2020



## УОК-ЫН ШИЙДВЭРИЙН ДАГУУ ТӨВИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД МОНГОЛ УЛСААС БНСУ-Д СУУГАА ЭСЯ-НЫ КОНСУЛЫН ХЭЛТЭС ДЭЭР АЖИЛЛАВ



ээлжээр Консулын хэлтэс дээр ажиллаж, үйлчлүүлэхээр ирсэн иргэдийн халууныг хэмжин, бүртгэл хөтлөн, гар ариутгаж маскгүй иргэдэд маск тараан, нутаг буцахыг хүссэн иргэдийн өргөдлийг хүлээн авч шалган Консулын хэлтсийн ажилтанд орой бүр хүлээлгэн өгсөн билээ. Энэ хугацаанд Консулын хэлтсээр үйлчлүүлсэн 14,438 иргэнийг бүртгэлжүүлэн, нутаг буцах хүсэлт гаргасан 1,765 иргэний өргөдлийг хүлээн авч холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлаас шалтгаалан өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулж УОК-ын шийдвэрийн дагуу Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин Сайдын Яамтай шууд холбоотой ажиллав. 2020 оны 03 дугаар сарын 02-14-ний хооронд ЭСЯ-ны Консулын хэлтэст мэргэжилтэн А.Лхагвамаа, Т.Дарханбаатар нар ажиллаж **1892** иргэнийг халдваргүйжүүлэн бүртгэсэн бөгөөд 2020 оны 07 дугаар сарын 15-наас 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд ХНХҮТ-ийн бүх мэргэжилтнүүд



## БНСУ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэг эрхлэх газартай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав. БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд сүүлийн жилүүдэд ажлын байран дээрх үйлдвэрийн осол, гэмтэлд ихээр өртөж байна. 2019-2020 оны байдлаар ажлын байран дээрх үйлдвэрийн осолд өртөн тус төвд хандсан нийт 403 Монгол Улсын иргэнд Солонгосын Хөдөлмөр халамжийн корпораци, Үйлдвэрийн ослын даатгалын газраас **345,371,476** воны нөхөн олговор олгуулсан дүн мэдээ бий. Дээрх үйлдвэрийн осол гэмтлийн тоог бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Төвийн дарга Д.Баярмандах нь БНСУ





Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэг эрхлэх газрын сургалтын төвийн холбогдох удирдлагуудтай 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдөр уулзалт хийж Монгол Улсын иргэдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хамтран ажиллахаар харилцан тохиролцсон байна.



“Хамтран ажиллах гэрээ”-ний үндсэн зорилго нь БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй монгол иргэдийг үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор сургалтанд хамруулах, мэдээ мэдээллээр хангах, сургалтын материалыг монгол хэл дээр эмхтгэн гаргаж түгээх, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн мэргэжилтнүүдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, мэргэжлийн ур чадварыг бэхжүүлэх сургалтанд хамруулах болон хүний нөөцийн туршлага судлан үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэгт чиглэгдэж байгаа юм.

## АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭГЧ 16 ОРНЫ ЭВ НЭГДЛИЙН “ХАНМАДАН” НААДАМД УЛС ОРНОО СУРТАЛЧЛАН ОРОЛЦОВ



2019 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас жил бүр уламжлал болгон зохиогддог илгээгч 16 улсын “Ханмадан” эв нэгдлийн наадамд оролцож улс орныхоо түүх соёлыг сурталчлав. БНСУ-д гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоо үүсч хөгжсөний 15 жилийн хүрээнд илгээгч 16 улсыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлэг болов.

Уг хэлэлцүүлгээр БНСУ-ын Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны өнөөгийн байдал болон хэтийн төлөв, Солонгосын нийгмийн хүн амын өөрчлөлт ба гадаад ажиллах хүчний талаарх бодлого, ажиллах хүчний шилжих хөдөлгөөн ба хөдөлмөр эрхлэлтийн зөвшөөрөл

зэрэг сэдвүүдээр салбарын судлаач, эрдэмтэд, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны мэргэжилтнүүд илтгэл тавьсан бөгөөд хэлэлцүүлэгт ХХҮЕГ-ын дарга Б.Нямдаваа болон БНСУ дахь ХНХҮТ-ийн төлөөлөл оролцов.

**БНСУ-д 2,415,714 гадаад иргэн оршин сууж буйгаас 277,473 иргэн Е-9 визээр хөдөлмөр эрхэлж байна.**


2019 оны 7 дугаар сарын байдлаар хууль бусаар оршин сууж буй иргэдийн тоо **370,000**-д хүрсэн нь 10 жилийн дундажтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт аж. 2004 оноос БНСУ-д хөдөлмөр эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн бөгөөд өдгөө 15 жилийн хугацаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “тогтолцоо” хэмээн үнэлэгдэж байна.



# 2019

БНСУ-ЫН АЖ ҮЙЛДВЭР,  
ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
НЭРЭМЖИТ ШАГНАЛААР  
ШАГНАГДСАН **АНХНЫ**  
**БАЙГУУЛЛАГА БОЛОВ**

2019 оны 12 дугаар сарын 23-нд “БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн тусгай зөвшөөрлийн дагуу тус улсад амьдарч буй монгол иргэдийн оршин суух асуудалд дэмжлэг үзүүлж, ажил олгогч, ажилчин хоорондын хууль ёсны эрх үүргийг ханган ажиллахад оруулсан хүчин зүтгэлийг өндрөөр үнэлж” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийг БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал, Үндэсний тэтгэврийн хэрэг эрхлэх газрын шагналаар шагнаж төвийн дарга Д.Баярмандахад гардуулж өглөө. БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь энэхүү нэр хүндтэй шагналыг хүртсэн анхны Монгол байгууллага болсон юм.



**АЗИ НОМХОН ДАЛАЙН ОРНУУДЫН  
ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ  
СУРГАЛТАНД ОРОЛЦОВ**



2019 оны 06 сарын 17–22-ны өдрүүдэд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албаны Олон улсын хамтын ажиллагааны төвөөс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг дэлхийн 13 орны нийгмийн даатгалын албан хаагчдад зориулсан сургалт боллоо. Тус сургалт нь өөрийн орны нийгмийн хамгааллын тогтолцоог Солонгосын тогтолцоотой харьцуулж, зөв зүйтэй

санал, оновчтой туршлагыг өөрийн орны хөрсөн дээр буулгах, харилцан туршлага солилцох бололцоог олгодгоороо онцлог юм. Сургалтанд Монгол Улсаас НДЕГ-ын Мэдээллийн технологийн төвийн дарга Г.Хүрэлбаатар болон БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн мэргэжилтнүүд оролцов.

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ

2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр БНСУ-ын Чэжү аймгийн Чэжү хотод Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн хэрэг эрхлэх газрын хооронд мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав. Арга хэмжээнд Монгол Улсаас НДЕГ-ын дэд дарга



Г.Саран, Мэдээллийн технологийн төвийн дарга Г.Хүрэлбаатар, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах, БНСУ талаас Үндэсний тэтгэврийн албаны Мэдээлэл технологийн төвийн дарга Ким Дэ Сүн, Мэдээлэл технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Жон Ил Ху тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

## БНСУ-ЫН АЖ ҮЙЛДВЭР, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРААС ЦАР ТАХАЛТАЙ ХОЛБОГДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН “EPS CONFERENCE 2020” ЧУУЛГА УУЛЗАЛТАД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ

2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Өмнөд Гёнсан мужийн Тунёон хотноо БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “2020 EPS CONFERENCE” чуулга уулзалтад хөдөлмөрийн атташе Б.Оргил, ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах, тасгийн дарга Я.Энхбаясгалан нар мэргэжилтнүүдийн хамт оролцов. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу ажиллах хүч илгээгч 16 улсын элчин сайд, хөдөлмөрийн атташе, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга нар бүхий 80 орчим хүн оролцсон томоохон уулзалт болсон бөгөөд оролцогчид EPS АҮХНХЭГ-т хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ирэхээр хүлээгдэж буй иргэдийг Солонгос улсад нэн яаралтай ирүүлэх, нутагтаа түр чөлөөгөөр болон амралтаараа яваад ирж буй гэрээт ажилчид үйлдвэрийн

байрандаа тусгаарлагдах боломжгүй тохиолдолд улсын тусгаарлалтын зардалд төлж байгаа **1400.000** **воны 50 хувийг ажил олгогч** хариуцах боломж зэргийг судлах, хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсон гэрээт ажилчид хилийн хоригоос болж нутаг буцах боломжгүй, ажлын байргүй болсны улмаас амьдрах байр, хоол, амьжиргаагаа залгуулахад хүнд байгаа тул өмнө нь 50 хоногоор автоматаар сунгасан гэрээт ажилчдын оршин суух хугацааг тухайн үйлдвэрт нь хөдөлмөр эрхлэх нөхцлөөр дахин сунгах гэх мэт санал хүсэлтээ илэрхийлэв. АҮХНХЭГ-ын дарга Ким Дун Ман, Гадаад ажиллах хүч хариуцсан газрын дарга Ли Бён Үг нар “Хилийн хориг болон өөрийгөө тусгаарлах журам заавар нь зөвхөн гадаад улс орны иргэдэд тавьж буй хатуу шаардлага бус өөрийн улсын иргэн ч гадаадаас хил нэвтрэн орж ирэхэд дагаж мөрдөж байгаа шаардлага журам юм. Covid-19



цар тахлын энэ хэцүү цаг үед та бүхэн манай улсын нөхцөл байдлыг харгалзан үзэж зөв бодлого баримтлан хүлээгдэж буй иргэддээ нөхцөл байдал намжтал тайван хүлээцтэй байхыг, эрүүл мэндээ сахин хамгаалах нэн чухал байгаа цаг үеийн бодит байдлыг ойлгуулах нь чухал байна. Шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулан ирэх гэж буй гэрээт ажилчдын хувьд Солонгос улсад “Өөрийгөө тусгаарлах журам”

бүрэн цуцлагдсаны дараа хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох бодлого төрөөс баримталж байна. Энэ хүнд цаг үед манай төрөөс зөв бодлого баримтлан халдвар тархалтыг бууруулах тал дээр хичээн ажиллаж байгаа тул ойрын хугацаанд нааштай шийдэгдэх болно гэдэгт итгэлтэй байна. Ажиллах хүч илгээгч 16 улсын төлөөлөгчид та бүхэн бидний хамтын оролцоо дэмжлэг чухлыг онцлон тэмдэглэж байна” хэмээсэн юм.



2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр БНСУ-ын АҮХНХЭГ-ын хурлын танхимд илгээгч 16 улсын ЭСЯ, хөдөлмөрийн атташе, БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга нар оролцсон шуурхай зөвлөгөөн болж тус төвийн дарга Д.Баярмандах холбогдох мэргэжилтнүүдийн хамт оролцов.

# БНСУ-Д АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭГЧ 16 ОРНЫ ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, ХӨДӨЛМӨРИЙН АТТАШЕ, БНСУ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮН НАРЫН УУЛЗАЛТАНД ОРОЛЦОВ



Зөвлөгөөнөөр түр нутаг буцсан хөдөлмөрийн гэрээт ажилчид Солонгос улсын хилээр орж ирэхэд тусгаарлах байрны баталгаа хуудсыг зайлшгүй бөглөн баталгаажуулсны дараа хилээр нэвтрэх эрх үүсэх, тусгаарлах байрны хяналтыг чангатгах асуудлаар харилцан санал солилцож шийдвэрлэсэн юм.



## БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭТ ИРГЭД БОЛОН НИЙТ МОНГОЛЧУУДАД “НЭГ ЦЭГ” СЭТГҮҮЛЭЭР АЛБАН ЁСНЫ МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙГ УЛИРАЛ ТУТАМ ХҮРГЭЖ БАЙНА

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвөөс хөдөлмөрийн гэрээт иргэд болон Солонгост суугаа монголчуудад зориулсан “Нэг цэг” сэтгүүлийг хэвлүүлэн хүргэж байна. Энэ нь Солонгос улсад монгол хэлээр гарч буй анхны сэтгүүл юм. Сэтгүүлийг БНСУ-ын хамтран ажилладаг байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэвлүүлж, үнэгүй тарааж байна.

“Нэг цэг” сэтгүүл нь улирал бүр 36-60 нүүрээр хэвлэгдэн гарч байгаа бөгөөд төвийн мэргэжилтнүүд “Мэргэжилтэн зөвлөж байна”, “Хууль эрхзүйн мэдээлэл” гэх зэрэг булангууд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалт, сэрэмжлүүлэг, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд зайлшгүй шаардлагатай мэдээ мэдээллүүдийг бэлтгэн хөдөлмөрийн гэрээт иргэд болон Солонгост суугаа монголчуудын гарт хүргэж байна.







2004-2021

Ирж ажилласан  
иргэдийн тоо

29,439

**БНСУ-ын "Хөдөлмөр  
эрхлэх зөвшөөрөл олгох  
тогтолцоо"-ны дагуу 2004  
оноос эхлэн хөдөлмөрийн  
гэрээт иргэдийг хүлээн авч  
эхэлсэн байдаг.**

## МОНГОЛ УЛСААС БНСУ-Д ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАСАН ИРГЭДИЙН ТОО /2004-2021 ОН/

д/д	он	Бүгд	Хүлээн авсан өргөдлийн тоо	Нийт олгуулсан мөнгөн дүн / воноор/
1	2004	499		
2	2005	4,425		
3	2006	4,681		
4	2007	2,354		
5	2008	2,638		
6	2009	1,324		
7	2010	1,872		
8	2011	1,066		
9	2012	2,508	5,768	348,414,685
10	2013	1,952	5,422	401,937,676
11	2014	1,278		
12	2015	1,119		
13	2016	984	1,762	221,858,548
14	2017	1,294	5,123	597,773,038
15	2018	703	5,253	1,272,418,324
16	2019	719	5,741	1,180,277,109
17	2020.01	23	7,861	948,234,862
18	2021		5,229	1,084,502,031
	<b>Нийт</b>	<b>29,439</b>	<b>42,159</b>	<b>6,055,416,273 вон 15,138,540,682 төг</b>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2011 оноос 2021 оны 10 дугаар сарын 31-ний хооронд иргэд, байгууллага, ажил олгогчоос хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдүүлэхээр танхим, факс болон утсаар нийт **42,159** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн биржүүд, БНСУ-ын Үйлдвэрийн ослын даатгалын газар, ажил олгогч эздүүд, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар, шүүх, прокурор болон бусад холбогдох байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээг үзүүлж ажиллав. БНСУ-ын "Самсунг" даатгалын газраас гэрээт ажилчидтай холбоотойгоор оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгал, ажил олгогчоос олгогдоогүй цалин хөлс, гэнэтийн ослын даатгалаас нөхөн олговор зэрэгт нийт **6,055,416,273** вон, 2004 оноос 2021 оны 09 дүгээр сарын хооронд үйлдвэрийн ослын даатгалын газраас үйлдвэрийн осолд орсон иргэдэд нөхөн олговор, ажилгүйдлийн тэтгэмж, эмчилгээний зардалд **42,491,029,510** воныг олгосон бөгөөд үүний 50% буюу 20 орчим тэрбум воныг БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн мэргэжилтнүүдээр дамжуулан олгуулж ажилласан байна.

**Тайлант хугацаанд нийт 48,546,445,783 вон буюу 121,366,114,457 төгрөгийг /нэг зуун хорин нэгэн тэр бум гурван зуун жаран зургаан сая нэг зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун тавин долоон төгрөг/ иргэдэд олгуулж ажиллав.**

### 1.ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ИРГЭДЭД

Нутаг буцах замын зардалд	<b>460,186,063 вон</b>
Цалин хөлс, илүү цагийн хөлс	<b>294,462,816 вон</b>
Самсунг даатгалаас 13 дахь сарын цалин	<b>3,107,419,662 вон</b>
Үйлдвэрээс олгох 13 дахь сарын цалингийн зөрүү	<b>563,554,149 вон</b>
Үйлдвэрийн ослын даатгалын газраас	<b>24,212,584,730 вон</b>
Гэнэтийн ослын даатгалаас нас барсны нөхөн олговор	<b>90,000,000 вон</b>
Эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлгийн төлбөр хөнгөлөх	<b>495,706,519 вон</b>
Бусад олговор /сэтгэл санааны хохирол/	<b>4,523,880 вон</b>
Гэнэт халагдсаны тэтгэмж	<b>4,000,000 вон</b>

### 2.ХУУЛЬ БУСААР АЖИЛЛАЖ БУЙ ИРГЭДЭД

Үйлдвэрийн ослын даатгалын газраас	<b>18,278,444,780 вон</b>
Олгогдоогүй цалин хөлсөнд	<b>267,481,094</b>
воныг тус тус олгуулж ажиллав.	

## БНСУ-Д ҮЙЛДВЭРИЙН ОСОЛД ОРСОН ИРГЭДИЙН ТОО БОЛОН ДААТГАЛЫН ГАЗРААС ОЛГУУЛСАН МӨНГӨН ДҮН /2004 оноос 2021 оны 09 дүгээр сар хүртэл/

<b>БНСУ–д хөдөлмөр эрхэлж байгаад үйлдвэрийн осолд орсон Монгол иргэдийн тоо, олгосон нөхөн олговрын дүн</b>			
(нэгж: Хүний тоо, вон)			
Ангилал		Үйлдвэрийн осолд орсон иргэдийн тоо	Нөхөн олговор
<b>2004 он</b>	Дадлагажигч	15	56,934,940
	Гэрээт ажилчин	53	432,079,150
	Бусад	72	1,455,910,450
	<b>Нийт</b>	<b>140</b>	<b>1,944,924,540</b>
<b>2005 он</b>	Дадлагажигч	25	281,112,450
	Гэрээт ажилчин	57	505,530,430
	Бусад	62	1,196,092,680
	<b>Нийт</b>	<b>144</b>	<b>1,982,735,560</b>
<b>2006 он</b>	Дадлагажигч	21	157,821,490
	Гэрээт ажилчин	167	1,503,888,320
	Бусад	42	841,483,200
	<b>Нийт</b>	<b>230</b>	<b>2,503,193,010</b>
<b>2007 он</b>	Дадлагажигч	18	235,190,570
	Гэрээт ажилчин	217	1,820,789,950
	Бусад	49	1,051,483,880
	<b>Нийт</b>	<b>284</b>	<b>3,107,464,400</b>
<b>2008 он</b>	Дадлагажигч	17	196,809,590
	Гэрээт ажилчин	242	2,020,341,950
	Бусад	35	913,775,920
	<b>Нийт</b>	<b>294</b>	<b>3,130,927,460</b>
<b>2009 он</b>	Дадлагажигч	16	115,392,700
	Гэрээт ажилчин	204	1,826,743,990
	Бусад	57	1,336,206,670
	<b>Нийт</b>	<b>277</b>	<b>3,278,343,360</b>
<b>2010 он</b>	Дадлагажигч	4	13,760,560
	Гэрээт ажилчин	186	1,449,640,810
	Бусад	56	670,826,000
	<b>Нийт</b>	<b>246</b>	<b>2,134,227,370</b>
<b>2011 он</b>	Дадлагажигч	2	7,819,440
	Гэрээт ажилчин	174	1,671,631,740
	Бусад	38	794,879,650
	<b>Нийт</b>	<b>214</b>	<b>2,474,330,830</b>
<b>2012 он</b>	Дадлагажигч	1	45,890,890
	Гэрээт ажилчин	176	1,360,854,070
	Бусад	28	361,710,290
	<b>Нийт</b>	<b>205</b>	<b>1,768,455,250</b>

2013 он	Дадлагажигч	2	46,189,520
	Гэрээт ажилчин	143	1,157,946,750
	Бусад	25	773,512,890
	<b>Нийт</b>	<b>170</b>	<b>1,977,649,160</b>
2014 он	Дадлагажигч	2	34,391,240
	Гэрээт ажилчин	99	818,597,470
	Бусад	24	327,067,290
	<b>Нийт</b>	<b>125</b>	<b>1,180,056,000</b>
2015 он	Дадлагажигч	2	14,389,490
	Гэрээт ажилчин	100	844,376,580
	Бусад	28	789,643,390
	<b>Нийт</b>	<b>130</b>	<b>1,648,409,460</b>
2016 он	Дадлагажигч	5	151,266,570
	Гэрээт ажилчин	98	873,751,530
	Бусад	30	641,424,570
	<b>Нийт</b>	<b>133</b>	<b>1,666,442,670</b>
2017 он	Дадлагажигч	3	15,535,690
	Гэрээт ажилчин	93	1,117,538,820
	Бусад	46	880,780,730
	<b>Нийт</b>	<b>142</b>	<b>2,013,855,240</b>
2018 он	Дадлагажигч	3	179,183,620
	Гэрээт ажилчин	93	1,074,447,480
	Бусад	59	1,137,591,120
	<b>Нийт</b>	<b>155</b>	<b>2,391,222,220</b>
2019 он	Дадлагажигч	3	20,142,410
	Гэрээт ажилчин	125	1,407,207,600
	Бусад	67	1,564,167,040
	<b>Нийт</b>	<b>195</b>	<b>2,991,517,050</b>
2020 он	Дадлагажигч	0	0
	Гэрээт ажилчин	132	1,646,907,440
	Бусад	82	1,837,127,220
	<b>Нийт</b>	<b>214</b>	<b>3,484,034,660</b>
2021 он 9 сар	Дадлагажигч	2	85,150
	Гэрээт ажилчин	95	1,108,394,330
	Бусад	86	1,704,761,790
	<b>Нийт</b>	<b>183</b>	<b>2,813,241,270</b>
	<b>Нийт дүн</b>	<b>3481</b>	<b>42,491,029,510</b>
	<b>Нийт олгуулсан дүн /төгрөгөөр/</b>		<b>106,227,573,775</b>





## БНСУ-Д ОРШИН СУУЖ БАЙГАА ИРГЭДИЙГ НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРУУЛСАН БАЙДАЛ /2007-2021 он/



Тэтгэврийн даатгал

23,861



Сайн дурын даатгал

1,782

Д/д	Он	Даатгуулагчдын тоо /давхардсан/			
		Нийт	Шинээр хамрагдсан /давхардсан/		
			Тэтгэврийн даатгал	Сайн дурын даатгал	Нийт
1	2007	5,490	5,490		5,490
2	2008	9,232	3,742		3,742
3	2009	10,837	1,605		1,605
4	2010	12,501	1,664		1,664
5	2011	13,812	1,311		1,311
6	2012	16,196	2,384		2,384
7	2013	18,309	2,113		2,113
8	2014	19,767	1,484		1,484
9	2015	20,958	1,272	140	1,412
10	2016	21,414	393	340	733
11	2017	21,933	1080	470	1,550
12	2018	23,170	607	204	811
13	2019	23,872	612	231	843
14	2020	23,989	99	234	333
15	2021.10.31	24,059	6	163	140
Нийт дүн		24,059	23,861	1,782	25,643

Энэ хугацаанд давхардсан тоогоор **23,861** иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд, **1,782** иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулан, нийгмийн даатгалын санд **18.4 тэрбум вон буюу 31.4 тэрбум** төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлсэн байна.



## БНСУ-ЫН ҮНДЭСНИЙ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН БУЦААН ОЛГОЛТ АВСАН МОНГОЛ ИРГЭДИЙН ТОО, ОЛГОГДСОН ДҮН



Буцаан олголт авсан  
иргэдийн тоо

15.995



Буцаан олголтын дүн  
/сая вон/

26.184

2007 оноос 2020 оны 6 дугаар сарын эцэс хүртэлх хугацаанд Монгол Улсын **15,995** иргэн нийт **26 тэрбум 184 сая воны** нэг удаагийн буцаан олголтыг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын сангаас авсан байна. Үүнээс Инчон олон улсын нисэх онгоцны буудлаас дээрх хугацаанд **2,307 иргэн 8 тэрбум 484 сая воны** буцаан олголтыг нутаг буцахдаа бэлэн мөнгөөр авсан байна.

Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 2007 оноос 2020 оны 6 дугаар сарын эцэс хүртэлх хугацаанд НДЕГ-аар дамжуулан **5,437 иргэн 5 тэрбум 501 сая воны** буцаан олголтыг авсан байна.

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын шимтгэлийн буцаан олголт авсан монгол иргэдийн тоо, олгогдсон дүн

Д/д	Он	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олголтын дүн / сая вон/
1	2007	1,380	1,981
2	2008	5,012	5,336
3	2009	2,921	2,756
4	2010	648	655
5	2011	726	837
6	2012	1,074	1,636
7	2013	743	1,163
8	2014	730	1,452
9	2015	606	1,717
10	2016	395	1,181
11	2017	526	1,993
12	2018	572	2,373
13	2019	518	2,428
Д/д	2020.06	144	676
	<b>Нийт дүн</b>	<b>15,995</b>	<b>26,184</b>



ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯЛАГ




МОНГОЛ ИРГЭД НАМ ГИ СЭ  
ЭМНЭЛГЭЭР ХӨНГӨЛӨЛТТЭЙ  
ҮЙЛЧЛҮҮЛЖ БАЙНА



БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь 2019 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Нуруу нугас болон үе мөчний дурангийн фокус эмчилгээтэй “Нам Ги Сэ” эмнэлэгтэй “Хамтран ажиллах гэрээ” байгуулан хамтын ажиллагаагаа эхлүүлсэн билээ.

Уг хамтын ажиллагааны хүрээнд тус эмнэлгээр үйлчлүүлж буй Монгол Улсын иргэдэд тодорхой хэмжээнд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэхээр болсон юм. Тиймээс БНСУ-д оршин сууж буй Монгол Улсын иргэд энэхүү хөнгөлөлт, урамшууллыг хүртэх боломж бүрджээ.



2014 оны 11 сарын 10-нд байгуулагдсан тус эмнэлэг нь 11 эмч, 50 сувилагч, жолооч, захиргааныхан нийлсэн нийт 103 ажилтан албан хаагчидтай, 96 хүн нэг зэрэг хэвтэж эмчлүүлэх хүчин чадалтай эмнэлэг ажээ.



НАМ ГИ СЭ ЭМНЭЛЭГ

Бэлтгэгдсэн мэргэжлийн хамт олны ур чадвар, халуун дулаан сэтгэлийг “Нам Ги Сэ” эмнэлэг танд амлаж чадна



Хариуцсан ажиллантай  
холбогдох дугаар: 1577-2533  
Хаяг: БНСУ, Сөүл хот, Кандун  
дүүрэг, Чонху дэру 1133



**ХНХҮТ-ийн мэргэжилтэн  
Б.Ганцэцэг**

## МЭРГЭЖИЛТЭН ЗӨВЛӨЖ БАЙНА



*ХНХ-ын тасгийн мэргэжилтэн Б.Ганцэцэг энэ удаагийн “Мэргэжилтэн зөвлөж байна” булангаар олгогдоогүй цалин хөлсний асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө өглөө.*



### ОЛГОГДООГҮЙ ЦАЛИНГИЙН АСУУДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Ажил олгогчийн зүгээс тухайн ажилтанд хөдөлмөрийн хөлсийг нь төлөх ёстой хугацаанд нь / цалинг олгохоор тогтоосон өдөр/ төлөөгүй тохиолдолд олгогдоогүй цалингийн асуудал үүсдэг. Мөн тухайн ажилтанг ажлаас гарснаас хойш цалин болон тэтгэмжийн мөнгийг 14 хоногийн дотор олгоогүй тохиолдолд мөн олгогдоогүй цалинд хамааруулж болно. **ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ВЭ?** Тухайн ажлын байрны харьяалалтай орон нутгийн Хөдөлмөрийн маргаан шийдэх газарт өргөдөл гаргана. Өргөдөл гаргахдаа ажил олгогчийн хаяг, утасны дугаар, ажил олгогчийн овог, нэр зэрэг холбогдох мэдээллээс гадна хөдөлмөрийн гэрээ, цалингийн баримт, цалингийн дансны хуулга, ажилласан цагийн бүртгэл гэх мэт материалыг хавсаргана.

### ШИЙДВЭРЛЭХ ДАРААЛАЛ ЯМАР БАЙДАГ ВЭ?

Тухайн Хөдөлмөрийн маргаан шийдэх газраас иргэний гаргасан өргөдлийг хүлээн авч, судлан үзээд,

цалингийн өр авлага байгаа эсэхийг тодруулна. Олгогдоогүй цалин байгаа нь нотлогдвол эхлээд мөнгөн дүнг нь тогтоож, түүний дараагаар ажил олгогчид шаардлага хүргүүлнэ. Ажил олгогчоос дээрх шаардлагыг хүлээн зөвшөөрвөл тухайн иргэний цалингийн өр авлагыг барагдуулснаар дээрх асуудал эцэслэн шийдвэрлэгдэнэ. Хэрвээ Хөдөлмөрийн маргаан шийдэх газраас гаргасан шийдвэрийг ажил олгогч хүлээн зөвшөөрөхгүй байх юм уу аль эсхүл тухайн компани дампуурах зэрэг санхүүгийн чадваргүй болох нь тогтоогдвол дээрх хэрэг иргэний хэргийн шүүх рүү шилждэг. БНСУ-ын Хууль зүйн Яамны харьяа Хууль зүйн туслалцаа үзүүлэх төвд хандсанаар дээрх газраас улсын өмгөөлөгчөөр үнэ төлбөргүй хангаж өгч, асуудлаа шийдүүлэх бүрэн боломжтой.

### ОЛГОГДООГҮЙ ЦАЛИН ХӨЛСНИЙ НӨХӨН ТӨЛБӨРИЙГ УЛСААС ОЛГОХ ТОГТОЛЦОО ГЭЖ ЮУ ВЭ?

Ажил олгогч дампуурах зэрэг санхүүгийн чадваргүй болох нь тогтоогдвол улсаас олгогдоогүй цалингийн

тодорхой хувийг ажилтанд урьдчилан олгох тогтолцоог хэлнэ.

–Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөрийг өмнө нь ажилчин тухайн ажлаас гарсан тохиолдолд авах эрх үүсдэг байсан бол энэ оны 10 дугаар сараас эхлээд тухайн ажлын байран дээрээ одоо ажиллаж байгаа ч цалин хөлсөө авч чадахгүй байгаа ажилчин улсаас олгодог “Олгогдоогүй цалин хөлсний нөхөн төлбөр”-ийг авах хүсэлтээ гаргах боломжтой болж байна.

–Өмнө нь “Олгогдоогүй цалин хөлсний маргаан”-ы талаар хуулийн байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд дээрх нөхөн төлбөрийг авах боломж үүсдэг байсан бөгөөд шаардагдах хугацаа 7 сар орчим байв. 2021 оны 10 дугаар сараас эхлээд хуулийн байгууллагын шийдвэр гараагүй ч харьяа орон нутгийн Хөдөлмөрийн маргаан шийдэх газраас тухайн ажилчинд олгогдоогүй цалин хөлс буйг нотолсон бол дээрх нөхөн төлбөрийг авах боломжтой болж байна. Мөн хэрэг хэлэлцэхэд шаардагдах хугацаа 2 сар болж богиноссон нь иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд

илүү түргэн шуурхай болж өөрчлөгджээ.

–Олгогдоогүй цалин хөлсийг улсаас урьдчилан олгох нөхөн олговрын одоо мөрдөгдөж буй хэмжээ нь 10 сая хүртэлх вон (ажлаас гарсны тэтгэмж болон цалин хөлс багтаад) бөгөөд өөрөөр хэлбэл олгогдоогүй цалингийн асуудал нь Хөдөлмөрийн маргаан шийдэх газраас баталгаажсан бол 10 сая хүртэлх воны нөхөн олговрыг улсаас авах боломжтой болж байна.

### ОЛГОГДООГҮЙ ЦАЛИНГИЙН АСУУДЛААР ЯМАР ХҮН ӨРГӨДӨЛ ГАРГАХ БОЛОМЖТОЙ ВЭ?

Тухайн ажилчин хөдөлмөр эрхлээд түүнд ногдох хөдөлмөрийн хөлсөө авч чадаагүй нь үнэн бол гадаад дотоодын иргэн байх, хууль бусаар оршин суугч байхаас үл хамаарч “Солонгос улсын Хөдөлмөрийн стандарт хууль” нэгэн адил үйлчилнэ.

Ажил олгогчийн зүгээс ажилтанд цалин хөлсийг нь олгохгүй байх тохиолдолд хуулинд заасны дагуу 3 хүртэлх жилийн ял, 20 сая хүртэлх воны торгууль ногдуулдаг.



ТОДРУУЛГА



*Цар тахлын улмаас хэсэг завсарлаад байсан БНСУ-д илгээгч 16 орноос ажиллах хүч авах асуудал нааштай шийдэгдэж эхэлж байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэлээс тодруулга яриа авлаа.*



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл:

## ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ИРГЭДЭЭ ИЛГЭЭХ БОЛОН ХҮЛЭЭН АВАХ ТАЛААР **ХОЁР ТАЛ БАГАГҮЙ ХҮЧИН ЧАРМАЙЛТ ГАРГАН АЖИЛЛАЖ БАЙНА**

–Юуны өмнө БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн 10 жилийн ойн баярын мэндийг нийт хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагуудын удирдлагын багийн хамт олны өмнөөс дэвшүүлж, танай хамт олонд ажлын амжилт, сайн сайхныг хүсье!

–Баярлалаа. Урт удаан хугацаагаар хүлээсэн хөдөлмөрийн гэрээт иргэд Солонгос улс руу явж эхлэх гэж байна. Энэ дагуу хийгдэж буй ажлууд нэлээд бий байх?

–БНСУ-ын Засгийн газрын шийдвэрийн дагуу зарим улсад зөвхөн гэрээний ажилтныг COVID-19-ийн хоёр тун вакцинд хамрагдаж дууссанаас хойш 14 хоногийн дараа Солонгос улсын хилээр нэвтрүүлэхийг зөвшөөрч байгаа.

Энэ шийдвэрийн дагуу БНСУ гадаадаас ажиллах хүч авах асуудлыг нээлттэй болгоход анхаарал хандуулан ажиллаж Узбекистан, Киргистан, Пакистан, Мьянмар, Филиппин зэрэг улсаас ажиллах хүч авахаа албан ёсоор мэдэгдсэн бөгөөд эдгээр улс дотор Монгол Улс багтсанд талархалтай хандаж байна. Бид 2019 оны сонгон шалгаруулалтад тэнцэж, БНСУ-ын хөдөлмөрийн биржид ажил хайгчаар байршсан Монгол Улсын нэр бүхий иргэдээс нөхцөл байдлын судалгаа авах, эрүүл мэндийн давтан үзлэг шинжилгээнд хамруулах, виз мэдүүлэх, тийзний захиалга баталгаажуулах, явахаас 72 цагийн өмнө БНСУ-ын Элчин сайдын яамнаас заасан эмнэлэгт PCR шинжилгээ өгүүлэх, хилээр гарах зөвлөгөө мэдээллээр

хангах, явахаас нэг хоногийн өмнө тусгаарлах, иргэдийн саналд үндэслэсэн хувийн мэдээллийг нөгөө талд цаг тухайд нь хүргүүлэх зэрэг үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж байна.

–2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсаас БНСУ-д шинээр хөдөлмөрийн гэрээт ажилтан ирж байна. Хэдэн хөдөлмөрийн гэрээт ажилтан ирсэн бэ?

–Бидний илгээсэн мэдээллийн дагуу БНСУ-ын Аж үйлдвэр хүний нөөцийн хэрэг эрхлэх газар, ажил олгогчдоос өөрийн сонгосон гэрээт ажилтныг хүлээн авах тухай зөвшөөрлийг нь авч, 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн нислэгээр хүлээн авах 39 иргэний нэрсийн жагсаалтыг үндэслэн явах иргэдийн хувийн бэлтгэлийг хангуулж байна.

–2019 оноос хойш БНСУ-ын Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу сонгон шалгаруулалтад тэнцэж, хөдөлмөрийн гэрээт ажилтнаар илгээгдэх тов хүлээгдэж буй нийт хэдэн иргэн байгаа вэ?

–2019 оноос БНСУ-ын Гадаад ажил хайгчаар хөдөлмөрийн биржид нэр нь байршиж ажлын санал хүлээн авсан, явах тов хүлээгдэж буй 670 орчим иргэн байна.

Эдгээр иргэдийг анх Хөдөлмөрийн биржид байршиж, ажлын санал хүлээн авсан дарааллаар нь хүлээн авах тухай БНСУ-ын Аж үйлдвэр хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын Монгол Улс



дахь И Пи Эс төвөөс бидэнд албан ёсоор мэдэгдсэн. Өнгөрсөн хугацаанд гадаадад хөдөлмөрийн гэрээт ажилтан илгээгдээгүй байгаа гол шалтгааныг хүн бүр мэдэж, ойлгож байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Дэлхий нийтэд тархсан цар тахлын нөхцөл байдал харьцангуй намжмал байдалд шилжиж байгаа учраас хүлээгдэж буй иргэдээ илгээх болон хүлээн авах талаар хоёр тал багагүй хүчин чармайлт гарган ажиллаж байна.

#### **–Шинээр ирэх хөдөлмөрийн гэрээт иргэдээс ямар зардал гарахыг тодруулж өгнө үү?**

–БНСУ–ын АҮХНХЭГ–аас энгийн ангиллаар (Е–9) явах иргэдээс гарах зардлыг аль болох бага байлгахыг эрмэлзэж байгаа. Тухайлбал, тусгаарлалтын байранд байх хугацааг 14 хоног байсныг 10 хоног болгон өөрчилсөн. Тусгаарлалтын нэг хоногийн төлбөрийг 120,000 вон гэж тооцохоор 10 хоногийн нийт зардал 1,2 сая вон болж буурч байгаа юм. Үүнээс гадна БНСУ–ын талаас хилээр нэвтрэх иргэдийг халаасны нэмэлт мөнгөтэй (воноор) явахыг зөвлөж байгаа. Мөн явахын өмнөх сургалт, жигдрүүлэх хувцас, нислэгийн тийз, виз мэдүүлэг, визний хураамж, эрүүл мэндийн давтан үзлэг шинжилгээ, PCR шинжилгээ, Монгол Улсад тусгаарлагдах нэг хоногийн зочид буудлын төлбөр хураамжийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж буй иргэд өөрсдөө гаргана.

#### **–2019 оноос өнөөдрийг хүртэл тогтвортой ажилтнаар нийт хэдэн иргэн илгээсэн бэ?**

–Илгээгч байгууллагын хувьд цар тахлын нөхцөл байдал хүндхэн байсан ч иргэдээ аль болох явуулахыг зорьж 2019

онд 64 иргэн, 2020 онд 21, 2021 онд 22 иргэнийг тус тус хөдөлмөрийн гэрээт ажилтнаар явуулсан. Гэхдээ 2020 онд БНСУ бусад 16 улсаас хөдөлмөрийн гэрээт ажилтныг тус улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй байхад Монгол Улсаас дотоодын халдвар тархаагүй улс гэдэг шалгуураар дээрх иргэдийг тогтвортой ажилтнаар илгээж байсныг дурьдах нь зүйтэй. Энд мөн иргэдийн хувийн сахилга бат, хичээл зүтгэл байсныг хэлэх хэрэгтэй болов уу. 2022 оны ажиллах хүчний нөөц бүрдүүлэх зорилгоор Монголын талаас БНСУ–ын талд удаа дараа хүсэлт тавьсны дагуу 2021 оны энгийн болон тусгай шалгалтын бүртгэлийг 2021 оны 6, 7 дугаар сард цахимаар зохион байгуулж, энгийн шалгалтад 3480 иргэн, тусгай шалгалтад 83 иргэн тус тус бүртгүүлсэн. Бүртгэлд хамрагдсан иргэдийн дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулан, илгээгч байгууллагад хүргүүлснээр Солонгос хэлний түвшин тогтоох энгийн болон тусгай шалгалтыг тус тус баталгаажсан хуваарийн дагуу 2021 оны 9 сарын 1–нээс 10 сарын 19–ны хооронд Монгол Улсад амжилттай зохион байгууллаа. Дээрх энгийн шалгалтад 657, тусгай шалгалтад 44 иргэн тэнцсэн бөгөөд шалгалтын үр дүнг олон нийтэд зарласан байгаа. Цаашид илгээх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, шат дарааллын дагуу иргэдийг бусад үйлчилгээнд хамруулах, илгээх үйл ажиллагааны бэлтгэлийг хангахад анхаарч ажиллах болно.

#### **–Иргэдэд чухал шаардлагатай сэдвээр хэрэгтэй мэдээллийг өгсөн танд баярлалаа.**

–Та бүхэнд дахин ажлын амжилт хүсье. Баярлалаа.





# БНСУ-ЫН ДЭЖИН ИХ СУРГУУЛЬ

- **Дэжин:** 1992 онд анх үүсгэн байгуулагдсан. 4 жилийн сургалттай хувийн сургууль.
- **Зорилт:** Чин шударга, Итгэл хүндлэл, Бүтээлч хандлага
- **Оюутны тоо:** 10,542 (Гадаад оюутан – 351, Монгол оюутан – 3)
- **Багш сурган хүмүүжүүлэгч:** 606 (Багш –399, ажилтан албан хаагчид –207)
- **Нийт талбай:** 1,917,355m<sup>2</sup>
- **Байршил:** Генгиду Пучон хот

## Бүрэлдэхүүн сургууль

- Магистр – 4
- Бие даасан үндсэн 7 сургууль, 24 тэнхим, 9 факультет, үндсэн мэргэжил олгох 21
- Харьяа байгууллага – 19
- Үйлдвэр сургалтын бааз – 1
- Судалгааны лаборатори – 1
- Салбар судалгааны төв –22

Сөүлээс 30 минут явж очно (20 км)  
Инчон онгоцны буудлаас 1 цаг 30 мин


Дэжин их сургуулийн төрийн байгууллагаас авсан үнэлгээ

- БНСУ–ын Боловсролын яам, судалгааны хүрээлэнгийн “Боловсролоороо олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн их сургууль”
- БНСУ–ын Боловсролын яамны “Магадлан итгэмжлэгдсэн их сургууль”
- БНСУ–ын Боловсролын яамны “Дээд боловсролын чанарын батламж”
- БНСУ–ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны “Ажлын байранд зуучлах төвтэй их сургууль”
- БНСУ–ын Аж үйлдвэр, гадаад худалдааны яамны “Инженерийн боловсролын шинэчилсэн төв”



Гадаад оюутан суралцуулах эрх бүхий магадлан итгэмжлэгдсэн их сургууль  
2015 он ~ 2018 он

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээ  
2018 он ~ 2021 он



## ДЭЖИН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ХОТХОН





## БАКЛАВРЫН СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

<b>Хүмүүнлэг, соёл урлагийн сургууль</b>	Солонгос хэл судлал, түүх уран зохиол судлал, уран бүтээл судлал, англи хэл, англи хэл судлаач, орчин үеийн урлаг судлал Дүрслэх урлаг судлал, дизайн судлал, жүжиг–кино урлаг судлал
<b>Олон улсын худалдаа аж үйлдвэрийн сургууль</b>	Олон улсын эдийн засаг судлал, төрийн захиргаа удирдлага, олон улсын худалдаа, олон улсын орон судлал
<b>Олон нийтийн харилцаа, хүний нөөцийн сургууль</b>	Олон нийтийн хууль судлал, төрийн захиргаа удирдлага, мэдээллийн технологи, Нийгэм халамж үйлчилгээ, сургуулийн өмнөх насны боловсрол, хэвлэл мэдээлэл (Media Communication)
<b>Шинжлэх ухаан технологийн сургууль</b>	Математик, биологи, био шинжлэх ухаан, сувिलाхуйн ухаан, спорт судлал, хүнсний технологи судлал, барилга угсралтын систем судлал, Human барилга архитектор судлал
<b>HUMAN IT Техник инженерийн сургууль</b>	Human It судлал, аж үйлдвэр, техник инженерийн сургууль, цахилгаан электрон судлал, эрчим хүч, байгалийн эрчим хүч судлал, компьютер ашиглалт, техник тоног төхөөрөмж ашиглалтын инженер, автоматжуулах, шинэ материал үйлдвэрлэл, дахин боловсруулалтын технологи, аж үйлдвэрийн инженер

## СОЛОНГОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

<b>2021 онд хичээллэх хуваарь</b>	<b>1 жилд 4 улирал:</b> 10 долоо хоног (Да-Ба / 09:00 ~ 13:00 цаг) <b>Хаврын сургалт:</b> 2021.03.04 ~ 05.10 <b>Зуны сургалт:</b> 2021.05.28 ~ 08.03 <b>Намрын сургалт:</b> 2021.09.02 ~ 11.08 <b>Өвлийн сургалт:</b> 2021.11.25 ~ 2022.01.31
<b>Элсэх шалгуур</b>	Бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй төгсөгчид болон боловсролын байдал нь ижил түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой байх
<b>Сургалтын төлбөр (1жил)</b>	4,800,000 вон (1,200,000 вон / 1 улирал) <b>2,400,000 вон 1 жилд (600,000 вон/ 1– улиралд) 50% хөнгөлөлттэй дүн</b>
<b>Бүрдүүлэх материал</b>	Элсэх хүсэлт (Өөрийн танилцуулга (маягт авч бөглөөд илгээнэ), /хувь хүний нууцыг хадгалах Гэрээ, маягт дээр гарын үсэг зурах) Хөрөнгийн баталгаа (Эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын мэдүүлэг) Боловсролын байдлыг нотлох (Төгссөн сургуулийн диплом, дүнгийн хуулбар) Иргэний үнэмлэх болон гадаад паспортын хуулбар (өөрийн болон эцэг эхийн) Батлан даагчтайгаа төрөл садан гэсэн лавлагаа (Төрөл садны лавлагаа) Дансны хуулга (үлдэгдэл <b>9,000\$</b> доллараас доошгүй байх) Элсэлтийн хураамж ( <b>50,000 вон</b> )

## ОЮУТНЫ ДОТУУР БАЙР

Өрөөний ангилал	Өрөөний ангилал	Төлбөр	Барьцаа төлбөр	Хоолны төлбөр /багц/ бүр
				А (113 удаа)
Энгийн байр 2 хүний	1 улирал (15 долоо хоног)	<b>444,000 вон</b>	<b>30,000 вон</b>	<b>361,600 вон</b>
Шинэ байр		<b>946,000 вон</b>		







## БНСУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС ШИЙД ГАРВАЛ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭТ ИРГЭДИЙГ 2019, 2020, 2021 ОНД БҮРТГҮҮЛСЭН ДАРААЛЛААР ХҮЛЭЭЖ АВНА

2021 оны 9 сарын 30-ны өдөр БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн дарга Д.Баярмандах тус улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын Олон улсын хөдөлмөрийн гэрээт ажилтан, хүний нөөцийн асуудал эрхэлсэн дарга Ким Сон Жэтэй уулзаж цаг үеийн тулгамдсан асуудлуудаар ярилцлаа. Энэхүү уулзалтын үеэр Д.Баярмандах дарга 2019, 2020 онуудад хөдөлмөрийн гэрээт ажилтнаар бүртгүүлж, солонгос хэлний болон ур чадвар, эрүүл мэндийн шалгалтандаа тэнцэн Солонгос улсад ирэхээр бүхий л бэлтгэлээ хангаад хүлээж буй иргэдийн талаар БНСУ-



ын албан ёсны байр суурийг тодруулж гэрээт иргэдийг хэзээнээс хэрхэн хүлээн авах талаар асууж сонирхсон юм. АҮХНХЭГ-ын Олон улсын хөдөлмөрийн гэрээт ажилтан, хүний нөөцийн асуудал эрхэлсэн дарга Ким Сон Жэ “2019–2020 онд хөдөлмөрийн гэрээт ажилтнаар сонгон шалгаруулалтдаа тэнцэн хүлээгдэж буй иргэдийн нөхцөл байдлыг сайн ойлгож байгаа

ч ковид цар тахлын дэгдэлт эрчимтэй нэмэгдэж байгаагаас шалтгаалан БНСУ-ын Засгийн газраас шинээр ирэх гэрээт ажилчдын хилээр нэвтрүүлэх хугацааг хойшлуулсан хэвээр байна. Хэрвээ Засгийн газраас шийдвэр гарвал БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам гадаадаас ирэх хөдөлмөрийн гэрээт ажилчдыг 2019, 2020, 2021 онд бүртгүүлж тэнцсэн дарааллын

дагуу хүлээн авна. Солонгос улс нь хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу ажиллах хүч илгээх тухай “Санамж бичиг” байгуулсан илгээгч 16 улс орноос одоогийн байдлаар зөвхөн тогтвортой нөхцлөөр дахин ирж ажиллах гэрээт ажилчдыг цөөн тоогоор хэдхэн улсаас хүлээн авч байна. Монгол Улсаас энэ хугацаанд нийт 36 иргэн тогтвортой нөхцлөөр ажиллахаар ирсэн. Зорчигчид хилээр нэвтрээд 48 цагийн дотор Ковид-19 өвчний илрүүлгийн PCR шинжилгээнд хамрагддаг. Гэвч харамсалтай нь, өнгөрсөн 8 дугаар сарын 17-ны өдөр тогтвортойгоор 9 хүн ирснээс 1 хүний шинжилгээний хариу эерэг гарлаа. Цаашид PCR шинжилгээний чанар, баталгаан дээрээ анхаарах нь зүйтэй болов уу? Одоогоор бид ирэх 11 дүгээр сарын сүүлчээр тогтвортой нөхцлөөр дахин ирэх гэрээт ажилчдаа хүлээн авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна” гэв.

## ХНХҮТ ЦАР ТАХЛААС БОЛЖ ЗАВСАРЛААД БАЙСАН ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ АХИН ҮЗҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



БНСУ дахь ХНХҮТ нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон Солонгос улсад оршин сууж буй иргэддээ үйлчилгээг ойлгуулж явуулын үйлчилгээг бусад байгууллагуудтай хамтран болон дангаараа тогтмол хэрэгжүүлж ирсэн билээ.

Ковид19 цар тахлын улмаас энэхүү үйлчилгээ түр завсарлаад байсан бөгөөд 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Пусан хотод суугаа Консулын газар, Төрийн банк, Хаан банк зэрэг газруудтай хамтран Өмнөд Чолла мужийн Гуанжү хот болон ойролцоох орон нутагт оршин сууж, хөдөлмөр эрхэлдэг иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээг хүргэн ажиллав.


Энэхүү хамтарсан арга хэмжээнд төвийн Нийгмийн даатгалын тасгийн дарга Л.Доржсүрэн, мэргэжилтэн М.Гантулга, О.Даваажав, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн мэргэжилтэн А.Лхагвамаа нар оролцож 50 орчим иргэнд үйлчлэн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Иргэд хойшлогдсон цалин хөлсний маргаан, ажлын байр солих тухай мэдэгдлийн талаар, Монгол Улсын нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэтгэвэр, тэтгэмжийн талаарх мэдээлэл, зөвлөгөө, БНСУ-ын эрүүл мэндийн даатгал, нутаг буцах замын зардлын даатгал, оршин суух хугацаа дуусгавар болсны даатгалуудын талаарх зөвлөгөө мэдээллүүд авснаас гадна нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр хамрагдаж, нийгмийн даатгалын аппликейшний бүртгэл хийлгэн, баталгаажуулж авчээ.

Нэг өдрийн турш зохион байгуулсан тус арга хэмжээнд нийт 150 гаруй монгол иргэд иржээ.

## БНСУ-ЫН “ГЛОБАЛ ЛИДЕР АССЕТ” ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

2021 оны 10 сарын 21-ний өдөр ХНХЯ-ны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн байранд Төвийн дарга Д.Баярмандах, БНСУ-ын “Глобал лидер ассет” ХХК-ийн захирал Гил Мин Сү нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Тус санамж бичгийн хүрээнд “Глобал лидер ассет” ХХК нь хөдөлмөрийн гэрээт

иргэд болон Солонгост оршин суугаа монголчуудад хөнгөлөлттэй даатгалын үйлчилгээ үзүүлж ажиллах юм. Санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааны үеэр “Глобал лидер ассет” ХХК-иас ХНХҮТ-ийн Нийгмийн даатгалын тасагт нэн шаардлагатай байгаа 2 ширхэг компьютер бэлэглэв.



## ТӨВИЙН ДАРГА Д.БАЯРМАНДАХ БНСУ ДАХЬ МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ 11 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНД УРИЛГААР ОРОЛЦОЖ БАЯР ХҮРГЭЛЭЭ

2021 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Солонгост оршин суугаа монголчуудын хувьд нэгэн тэмдэглэлт өдөр тохиосон нь БНСУ дахь Монгол эмэгтэйчүүдийн нэгдсэн холбооны 11 жилийн ойн арга хэмжээ байлаа. Тус арга хэмжээнд БНСУ-д Монгол Улсаас суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Н.Эрдэнэтуяа, ХНХЯ-ны харьяа БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга

Д.Баярмандах нарын албаны хүмүүс урилгаар оролцож баяр хүргэв. ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах хэлсэн үгэндээ “ХНХЯ-ны эрхлэх асуудлын чиг үүргийн дагуу бидний гол зорилго зорилтоо болгож ажилладаг хүн амын хөгжил, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аутизмтай хүүхдүүд рүү чиглэсэн олон талт сайн үйлсийн ажлуудыг



санаачлан манай байгууллагатай хамтран хэрэгжүүлж ажилладаг тус холбооны түүхэн ой тохиож байгаад халуун баяр хүргэхийн ялдамд бидний цаашдын хамтын ажиллагаа улам бэхжиж, хүрээгээ тэлж өргөжих болно гэдэгт итгэлтэй байна” хэмээсэн билээ. БНСУ дахь Эмэгтэйчүүдийн нэгдсэн холбоо нь Солонгос улсад

үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын анхдагч нь бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвтэй хэд хэдэн томоохон ажил, арга хэмжээг амжилттай хамтран хэрэгжүүлж ирсэн ажил хэрэгч, бүтээлч, санаачлагч, сайн үйлсийг түгээн дэлгэрүүлэгч байгууллага юм.





# CITI UNIVERSITY

**Бидний уриа:  
“Мэдлэг бол хүч, эрх чөлөө”**

СИТИ их сургууль бүрэлдэхүүний дараах сургуулиудтай:

Монгол Улсын Боловсролын салбарын хувийн ууган их дээд сургуулиудын нэг “СИТИ” ИХ сургууль 1998 онд Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлөөр анхан шатны болон ахисан түвшинд 2005, 2010 онд магадлан итгэмжлэгдэж, 2012 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас аттестатчилагдсан.



- Бизнесийн сургууль
- Хүмүүнлэгийн сургууль
- Хууль зүйн сургууль
- Барилга, архитектур дизайны сургууль
- Гоо сайхны сургууль
- Урлагийн сургууль
- Ахисан түвшний сургууль

“Хүнлэг, соёлтой, өндөр мэдлэг, чадвартай иргэн бэлтгэх” эрхэм зорилготой “СИТИ” их сургууль оюутан залуусын сурч, боловсрох таатай орчин нөхцлийг бүрдүүлж, чадварлаг боловсон хүчин бэлтгэн, дээд боловсролын салбарт үнэтэй хувь нэмрээ оруулж байна.

Энэ хичээлийн жилд нийт 44 хөтөлбөрт 2000 шахам оюутан, залуус бакалавр, магистр, докторын түвшинд суралцаж байна.

## СУРАЛЦАХ ОРЧИН, ДЭД БҮТЭЦ

Сургалтын тав тухтай, тохилог орчин суралцах чадавхыг 20% хүртэл нэмэгдүүлдэг нь батлагдсан бөгөөд манай сургууль дэлхийн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн “Экосургууль” болохоор зорьж байна.



## ЗАЛУУ НАС, СПОРТ

Сургуулийн “СИТИ Аянга” баг Монголын оюутны сагсан бөмбөгийн спортын түүхэнд анх удаа Оюутны Лигийн аварга хэмээх эрхэм хүндтэй цолыг 3 удаа дараалан хүртсэн бахдам амжилтын эзэд болоод байна. Олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмж, агааржуулалтын систем бүхий спорт зааланд оюутан, залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдсэн.




СИТИ ИХ сургууль өнгөрсөн хугацаанд олон улсын томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд 2013 оноос Европын Холбооны дээд боловсролын тэтгэлэгт солилцооны “Erasmus Mundus Mobility Asia” хөтөлбөрийн Монгол Улс дахь албан ёсны түнш байгууллагаар сонгогдон амжилттай ажиллаж байна.



## Манай хаяг:

Монгол улс, Улаанбаатар,  
Денверийн гудамж, 7 дугаар  
хороо, Сүхбаатар дүүрэг, 14190  
Мэдээлэл авах: [www.citi.edu.mn](http://www.citi.edu.mn)  
Холбоо барих: [info@citi.edu.mn](mailto:info@citi.edu.mn),  
+976 77442244





# CITI UNIVERSITY

## ИННОВАЦ БИЗНЕС ХӨГЖЛИЙН ТӨВ "CITIZONE"

Уг төв нь хичээлээс гадуур оюутан суралцагсдын инновац, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, гарааны бизнес эхлүүлэх, гарааны компани байгуулахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилготой юм. Түүнчлэн тэдний санаа бодлоо хуваалцах, харилцан туршлага солилцох таатай, тохь тухтай орчин болж чадсан юм.

"CITIZONE"-оос жил бүр багш, оюутнуудын санаачлан, боловсруулсан инновац, бизнесийн төслийг шалгаруулж, 1-3 төсөлд тус бүр 30.000.000 хүртэлх төгрөгийн санхүүжилт олгон, хамтран ажиллах арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.



## ЧАДВАРЛАГ БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН БИДНИЙ БАХАРХАЛ

Манай сургуульд гадаад улсад магистр, доктор хамгаалсан, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, заах арга барилыг өндөр түвшинд эзэмшсэн судлаач, эрдэмтэн багш нараас гадна Япон, БНСУ, ОХУ-аас ирсэн мэргэжилтэн багш нар ажилладаг. Нийт багш нарын 30% эрдмийн зэрэг цолтой, 2-3 гадаад хэлтэй.



## ЭЛСЭЛТ АВАХ МЭРГЭЖИЛ

Та бүхэн СИТИ их сургуульд бакалавр, магистр, докторын түвшинд дараах мэргэжлүүдээс суралцахынхаа зэрэгцээ англи, франц, орос, хятад, солонгос, япон хэлийг сонгон суралцах бүрэн боломжтой юм.

### Бакалавр:

#### Бизнесийн удирдлагын тэнхим

Нягтлан бодох бүртгэл  
Менежмент  
Маркетинг  
Худалдаа

#### Аялал жуулчлалын тэнхим

Аялал жуулчлал  
Агаарын тээврийн үйлчилгээ  
Зочлох үйлчилгээ

#### Барилга – Архитектурын тэнхим

Архитектур  
Барилгын инженер  
Интерьер дизайн

#### Компьютер график дизайны тэнхим

График дизайн  
Хэвлэлийн дизайн  
Програм хангамж

#### Хувцас дизайны дизайны тэнхим

Хувцас дизайн  
Нэхмэлийн үйлдвэрийн технологи

#### Гоо сайхны тэнхим

Гоо заслын урлаг, технологи  
Үсчин стилист  
Арьс гоо засал

Химийн технологи  
Сувилахуй

### Хууль эрх зүйн тэнхим

Эрх зүй

### Гадаад хэлний тэнхим

Багш, гадаад хэл /Англи, Солонгос, Хятад, Орос, Япон/  
Орчуулагч, гадаад хэл  
Багш, Сургуулийн өмнөх насны боловсрол

### Сэтгүүл зүйн тэнхим

Сэтгүүл зүй

### Дуулаач, хөгжмийн урлагийн тэнхим

Багш, урлагийн боловсрол /Дуу, хөгжмийн багш/  
Дуулах урлаг  
Уртын дуулаач  
Эстрад дуулаач  
Дуурийн дуулаач  
Хөгжимдөх урлаг

### Кино драмын тэнхим

Жүжиглэх урлаг  
Бүжиглэх урлаг

### Магистр:

Бизнесийн удирдлага  
Аялал жуулчлалын менежмент  
Эрх зүй  
Хувцас дизайн  
Урлаг судлал  
Дуулах урлаг  
Боловсрол судлал  
Сэтгүүл зүй  
Гоо сайхан

### Доктор:

Урлаг судлал  
Бизнесийн удирдлага

*“Нэг цэг” сэтгүүлийн энэ дугаартаа Нийгмийн даатгалын сайн дурын даатгалын талаарх иж бүрэн мэдээлэл бэлтгэн хүргэж байна. Та манай төвийн Нийгмийн даатгалын тасгаас бэлтгэсэн мэдээллээс сайн дурын даатгалын талаарх бүрэн ойлголттой болоорой!*

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ



## Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ямар иргэд хамрагдах вэ?

Ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллаж гэрээ байгуулан ажиллаж байгаагаас бусад иргэн нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдаж болно. **Тухайлбал:**

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч
- Малчин
- Газар тариалан эрхлэгч
- Бичил уурхай эрхлэгч
- Чөлөөт уран бүтээлч
- Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн
- Гадаад улсад ажиллаж, амьдарч буй иргэн
- Оюутан суралцагч
- Бусад иргэн

**Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад ямар төрлийн даатгалд даатгуулж болох вэ?**

Сайн дурын даатгуулагч нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)–тай байгуулсан гэрээгээр

тохирсон хугацаанд өөрийн мэдүүлсэн хөдөлмөрийн хөлс, орлогоосоо дараах хувь, хэмжээгээр тооцон шимтгэлээ төлнө.

**Жишээ нь:** (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2020 онд 420 000 төгрөг) Даатгуулагчийн сард төлөх шимтгэл  $(420\,000 \times 13.5\%) = 56\,700$  төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд–11,5%
- Тэтгэмжийн даатгалд–1,0%
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд–1,0%

**0–3 насны хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхчүүд сайн дурын даатгалын шимтгэлийг хэрхэн төлөх вэ?**

- Албан журмын буюу ажил хөдөлмөр эрхэлж байсан эхийн төлөх шимтгэлийг ажил олгогчоос хариуцан төлнө.
- Нийгмийн даатгалын

сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх нь үүссэн сайн дурын даатгуулагч эх шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлнө.

**Жишээ нь:** Даатгуулагчийн сард төлөх шимтгэл  $(420\,000 \times 12.5\%) = 26\,250 = 26\,250$  төгрөг байна.

- Бусад буюу жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоолгоогүй хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эх сайн дурын даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн нөхцөлд 50 хувийг улсын төсвөөс хариуцан төлнө.

**Жишээ нь:** Даатгуулагчийн сард төлөх шимтгэл  $(420\,000 \times 12.5\%) = 26\,250 = 26\,250$  төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд–11,5%
- Тэтгэмжийн даатгалд–1,0%
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш дүнгээр сайн дураар даатгуулах бол тодорхойлсон цалин хөлснөөс 13,5 хувиар тооцож төлөх шимтгэлээс 26250 төгрөгийг хасч үлдсэн шимтгэлийг даатгуулагч төлнө.

**Жишээ нь:** Даатгуулагчийн сард төлөх шимтгэл  $(800\,000 \times 13.5\%) = 26\,250 = 81\,750$  төгрөг байна.

- Тэтгэврийн даатгалд–11,5%
  - Тэтгэмжийн даатгалд–1,0%
  - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд–1,0%
- Шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба хуулийн үйлчлэлд хүүхэд нь 3 нас хүрээгүй нийт эхчүүд хамаарна.





### Иргэд нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахдаа шимтгэл төлөх сарын орлогоо ямар журмаар тодорхойлох вэ?

- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай тохиролцон хоёр талын гэрээ байгуулах бөгөөд гэрээнд шимтгэл тооцох сарын орлого, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгнө.
- Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь Засгийн газрын баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.
- Шимтгэл тооцох сарын орлогын дээд хэмжээ тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

### Сайн дураар даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж болох уу?

**Болохгүй.** Зөвхөн нийгмийн даатгалын байгууллагатай

гэрээ байгуулсан сараас эхлэн гэрээгээр тохиролцсон хугацаанд шимтгэлээ төлнө.

### Сайн дураар даатгуулагч шимтгэлийн тооцоог ямар журмаар хийх вэ?

Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлбөл зохих шимтгэлээ банкны тооцооны салбарт орлогын мэдүүлгээр нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд тушаана. Уг орлогын мэдүүлгийг үндэслэн сайн дураар даатгуулагчийн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагч хийж, түүний төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын дэвтэрт нь тухай бүр бичиж баталгаажуулж байна.

### Сайн дураар даатгуулагч ямар тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцлах вэ?

Дараах тохиолдолд нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээгээ цуцална:

- Аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орох
- Тэтгэвэр тогтоолгох
- Хүүхэд нь 3 нас хүрсэн эхчүүд
- Нас барах зэрэг тохиолдолд шимтгэлийн тооцоог дуусгаж, аймаг, сум, дуургийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан/ сайн дураар даатгуулагчийн гэрээг цуцалсан шалтгааныг түүний нийгмийн даатгалын дэвтэрт бичиж баталгаажуулж өгнө.

### Сайн дураар даатгуулагч ямар төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй вэ?

Сайн дураар даатгуулагч хуульд заасан болзол, нөхцлийг хангасан тохиолдолд дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг авах эрхтэй.

### • Тэтгэврийн даатгалын сангаас

- Өндөр насны тэтгэвэр
- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

### • Тэтгэмжийн даатгалын сангаас

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж

### • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас

- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж
- Хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр
- Тэтгэврийн даатгалын шимтгэл
- Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардал
- Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллын тусламж, үйлчилгээний зардал

### Сайн дураар даатгуулагч нь шимтгэл төлөх талаар ямар үүрэг хүлээх вэ?

Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын шимтгэл





төлөх талаар дараах үүргийг хүлээнэ.

- Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг үнэн зөв тооцон гэрээнд заасан хугацаанд оршин суугаа аймаг, сум, дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын сангийн дансанд төлөх
- Шимтгэл төлсөн тухай орлогын мэдүүлэг /баримт /-ийг хариуцсан нийгмийн даатгалын байцаагчид ирүүлж, төлсөн шимтгэлээ нийгмийн даатгалын дэвтэрт бичүүлж, баталгаажуулж авах
- Өөр аймаг, нийслэл, сум дүүрэгт шилжин суурьших тохиолдолд төлсөн шимтгэлийн тооцоог нийгмийн даатгалын байцаагчтай хийж дуусган, гэрээг цуцлуулж, энэ тухай нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийлгэн баталгаажуулсан байх

### **Сайн дураар даатгуулагчид ямар тохиолдолд хариуцлага хүлээлгэх вэ?**

Сайн дураар даатгуулагч нь сард төлбөл зохих шимтгэлээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагатай байгуулсан гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.3 хувиар тооцож алданги төлнө.

Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

### **Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах асуудлыг ямар байгууллагад тавьж шийдвэрлүүлэх вэ?**

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах иргэд оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-тай гэрээ байгуулна.

Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж 1 хувийг даатгуулагч /

иргэн/, нөгөө хувийг нийгмийн даатгалын хэлтэс /байцаагч/-т хадгална.

### **Сайн дураар даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээлгэж болох уу?**

Болно. 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн сайн дураар даатгуулагчийн хувьд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансыг даатгуулсан өдрөөс нээнэ.

### **1995 оноос өмнө ажилласан хугацааг нэрийн дансны орлогод оруулан тооцох уу?**

#### **Тооцно.**

Та 1995 оноос өмнө ажилласан хугацаагаа тооцуулахын тулд хөдөлмөрийн дэвтэр, хөдөлмөрийн дэвтэргүй бол цэргийн батлах, архивын лавлагаа, ажилд орсон, гарсан тушаалын хуулбар зэргийг бүрдүүлж, оршин суугаа газрынхаа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын нийгмийн даатгалын

байцаагчаар 1995 оноос өмнө ажилласан хугацаагаа тооцуулах хэрэгтэй.

Сайн дураар даатгуулахад ямар баримт бүрдүүлэх вэ?

- Иргэний үнэмлэх
- 3x4 хэмжээний зураг – 2 ш
- 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр

### **Сайн дураар даатгуулагч нь үйлдвэрлэлийн осолд орсон тохиолдолд ослын актыг ямар байгууллагад хандаж тогтоолгох вэ?**

- Сайн дураар даатгуулагч нь осолд өртсөн тухайгаа оршин суугаа аймаг, сум, дүүргийнхээ эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс /ажилтан/-т мэдэгдэнэ.
- Ослын актыг аймаг сум, дүүргийн Засаг даргын томилсон байнгын комисс судлан тогтооно.



**ХНХҮТ–ийн мэргэжилтэн  
К.Зулзаяа**

## МЭРГЭЖИЛТЭН ЗӨВЛӨЖ БАЙНА



Нийгмийн даатгалын тасгийн мэргэжилтэн К.Зулзаяа даатгуулагч хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд хэрхэн тэтгэмж авах талаар зөвлөж байна.

## ТА НИЙГМИЙН ДААТГАЛАА ТӨЛЖ БАЙГААД ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН БОЛ ТЭТГЭМЖ АВАХ БОЛОМЖТОЙ

БНСУ–д ажиллаж буй Монгол иргэдийн 40 гаруй хувь хүнд, хортой нөхцөлд ажиллаж байна гэсэн судалгаа байдаг. Түүнчлэн бие нь хямрах, ажлын ачааллаа зөв хуваарилж чадахгүй, эрүүл мэнддээ анхаарал тавих, өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж, нөхцөл хангалтгүй, чийгтэй, нам дор газар, их ачаалалтай ажиллаж, амралт, хоол хүнсээ тохируулж чадаагүйгээс болж өвчин хүндрэх, ходоод, нойр булчирхай, элэг, бөөр, цагаан мах эргэх өвчин, үйлдвэрийн эрүүл ахуйн нөхцлөөс шалтгаалсан харшил, хөлний судас бүдүүрэх, нуруу, нугасны гэмтэлтэй болох байдал элбэг тохиолдож байна. Ажлын ачааллаас үүдэн эмнэлэгт үзүүлэх боломж гардаггүй, ажиллах явцдаа их, бага хэмжээний үйлдвэрлэлийн осолд өртөж, ажил

хөдөлмөртэй холбоотойгоор эрүүл мэндэд сөрөг өөрчлөлт гарч хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдах тохиолдол их гардаг.

Монгол улсын “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх заалтад “Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3, түүнээс дээш сарын хугацаагаар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй” гэж заасан байдаг. Иймд Солонгос Улсад ажиллаж амьдарч байгаа хэдий ч нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа тохиолдолд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах боломжтой юм.

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН ТЭТГЭМЖИЙГ ДАРААХ БАЙДЛААР БОДОЖ ОЛГОНО.

#### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

##### Шимтгэл төлсөн хугацаа:

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сар

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг дор дурдсан хувь хэмжээгээр бодно:

Шимтгэл төлсөн хугацаа	Тэтгэмж бодох хувь
5 хүртэл жил	50 %
5–14 жил	55 %
15 ба түүнээс дээш жил	75 %

**Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэмжийг авахдаа дараах байдлаар хүсэлт гаргана.**

#### 1.Хяналтын болон эмчлэгч эмч

Таны хяналтын болон эмчлэгч эмч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгох шаардлагатай гэж үзсэн тохиолдолд онош тодруулах, үзлэг шинжилгээнд

хамруулах, эмчлүүлэх зорилгоор аймаг (дүүрэг)–ийн БОЭТ, ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, СЭМҮТ, ХАБЭМТ–рүү илгээнэ. БОЭТ– Бүсийн оношлогоо эмчилгээний төв СЭМҮТ– Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв ЭМТ– Эрүүл мэндийн төв ХАБЭМТ– Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв

#### 2.Эмнэлэг хяналтын комисс

Эмнэлгийн хяналтын комисс нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст өвчтөн илгээх асуудлыг өөрийн эрх үүргийн хүрээнд шийдвэрлэдэг сум дундын эмнэлэг түүнээс дээш түвшний эмнэлгийн амбулатор, поликлиник, эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн үйл ажиллагаа явуудаг комисс юм.

#### 3.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс

Аймаг (дүүрэг)–ийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс ажиллана. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн

Үргэлжлэл нь 36–р нүүрт



(DAEJIN International Volunteers Association)

# САЙХАН ДЭЛХИЙ

■ “Дэжин олон улсын хүмүүнлэгийн сан” нь “Хүмүүн та хамгаас эрхэм” үзлийг эрхэмлэн хүний эрхийг дээдлэн, иргэдтэй хамтдаа илүү сайхан нийгмийг цогцлоон бүтээхийн төлөө төрөл бүрийн сайн үйлсийн аян өрнүүлдэг төрийн бус байгууллага юм. 1970 оноос эхлэн яаралтай тусламж дэмжлэг хэрэгтэй болсон нийгмийн эмзэг, хүнд давхаргын иргэдэд тусалж дэмжсээр ирсэн бөгөөд 2014 онд БНСУ-ын Гёнгиду мужийн захиргаанаас “Нийгмийн сайн үйлс түгээх хүмүүнлэгийн шилдэг байгууллага”-аар шалгарч итгэмжлэгдсэн өргөмжлөлт байгууллага болжээ. 2015 онд БНСУ-ын Сангийн яамнаас Нийгмийн халамжийн нийгэмлэгээр тодорхойлогдсон бөгөөд Солонгосын Засгийн газраас албан ёсоор төрийн бус байгууллагаар бүртгэжээ.

■ “Дэжин олон улсын хүмүүнлэгийн сан” нь дотооддоо эмзэг давхаргын иргэдийг аюулгүй, ая тухтай орчинд амьдруулах зорилгоор тэдний орон байрыг засч тохижуулах ажил хийж, агааржуулалтын хоолой кондэйшн, халаалтын бойлуур гэх мэт айл өрхүүдэд нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг ханган нийлүүлсээр иржээ. Түүнчлэн эрүүл, аюулгүй хүнс нийлүүлэх зорилгоор “Хайрын хүнс” хүргэлтийн хоол хүнс түгээж байна. Хөдөө орон нутагт байгалийн гамшигт өртөн гарз хохирол амссан иргэдэд яаралтай тусламжийн бараа хүргэж, гамшгийн үеийн хандивын тусламж үйлчилгээг газар дээр нь биечлэн очиж өгөх гэх мэтээр олон төрлийн нийгмийн сайн үйлсийн аяныг хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

## САЙН ҮЙЛСИЙН АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Айлын байр засаж тохижуулж байна



“Хайрын хүнс” нийлүүлэх аян зохион байгуулдаг



Үндэсний хөгжим, урлагийг таниулах үйл ажиллагаа өрнүүлж байна



Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах, усанд оруулах үйл ажиллагаа явуулдаг



COVID-19 цар тахлын үед хүмүүст маск хандивлах үйл ажиллагаа өрнүүлж байна



“Цэвэр гудамж” аяны үйл ажиллагаа



# ЭНХ АМГАЛАН ДЭЛХИЙГ БҮТЭЭЭ!

■ DIVA буюу “Дэжин олон улсын хүмүүнлэгийн сан” нь олон улсын нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн орны иргэд төдийгүй гадаадын, хөрш улс орны иргэддээ халуун дулаан сэтгэлийн тусламж, хандив илгээмжээ хүргэсээр ирлээ. Африкийн Кени, Этоп Улсад цэвэр усны худаг гаргах ажлыг хийж, газар тариалангийн сургалт зохион байгуулан, тусламжийн бараа илгээсэн ба Вьетнам улсын Засгийн газраас албан ёсны INGO үйл ажиллагаа явуулах эрх авч дунд сургуулийн барилга барьж, солонгос хэлний сургалтаар

дамжуулан үнэ төлбөргүй ажлын байраар хангах, сургалтын байр, сурах орчныг шинэчлэн сайжруулах ажлыг явуулж байна. Нэн ялангуяа цэвэршүүлж шүүсэн ундны ус уух аяны хүрээнд цэвэршүүлэх шүүлтүүр угсарч, эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийх, эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлах аян зохион байгуулж цаашлаад эрүүл ахуйн орчин нөхцлийг сайжруулах цогц ажлуудыг хэрэгжүүлэн олон улсын NGO төрийн бус байгууллага болохын хувьд нийгмийн үүрэг хариуцлагаа улам өргөжүүлэн идэвхжүүлж байна.

## ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ ТУСЛАМЖИЙН АЯНЫ ХҮРЭЭНД



Эмзэг давхаргын айл өрхөд  
байшин барих үйл ажиллагаа



Дунд сургуулийн барилга байгууламж  
барих үйл ажиллагаа /Вьетнам Улс/



Цэвэр усны худаг барих үйл ажиллагаа /Кени Улс/



Бор-Өндөр суманд зохион байгуулсан сайн  
үйлсийн аян /Монгол Улс/



Солонгос хэлний сургалтаа дүүргэн гэрчилгээ  
хүлээн авч буй оюутнууд



Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж  
буй үйл ажиллагаа

Эхлэл нь 33-р нүүрт

## ТА НИЙГМИЙН ДААТГАЛАА ТӨЛЖ БАЙГААД ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРАА АЛДСАН БОЛ ТЭТГЭМЖ АВАХ БОЛОМЖТОЙ

чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх, ажлын цаг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэдэг. “Эмнэлэг хяналтын комиссын хурлын дүгнэлт гараагүй иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгох асуудлыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэхгүй.”

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Эмнэлэг хяналтын комиссоос илгээсэн иргэн (даатгуулагч)-ий биеийн байдал, шинжилгээ, оношилгоо, онош, өвчний үе шатыг тодорхойлсон бичиг баримттай танилцан дахин магадлах шаардлагатай гэж үзвэл холбогдох үзлэг оношилгоог давтан хийсний дараа тухайн иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох асуудлыг шийдвэрлэнэ.

Иргэн (даатгуулагч) хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол эхний удаад 3-24 сараар, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол 3-12 сараар тус тус тогтооно.

**4.**Хэрэв өвчин эмгэг, гэмтлийн байдал нь хөдөлмөрийн чадвараа хагас алдахад хүргэсэн бол идэвхтэй хяналтад 3 сар хүртэлх хугацаанд эмчлэн, эмчилгээний үр дүнг харгалзан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь

хэмжээ, хугацааг тогтоох эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ. Иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэхгүй нь тогтоогдвол иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалтын дагуу түүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг хугацаагүйгээр тогтоож болно.

**5.**Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг тогтоосон хугацаанаас 14 хоногийн өмнө эсвэл хойно комиссын хурлаар хэлэлцүүлж болно. Хэрэв иргэн (даатгуулагч) нь эмчилгээ зөвлөгөөг хэрэгжүүлээгүй, хяналтын үзлэгт хамрагдаагүй тохиолдолд эмчлэгч эмч нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг бууруулах, цуцлах хүртэлх арга хэмжээний саналыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст гаргаж болно.

**6.**Гадаад улсад удаан хугацаагаар эмчлүүлж байгаа иргэн (даатгуулагч)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгах, цуцлахдаа эрүүл мэндийн байгууллагын болон тухайн улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яамны тодорхойлолт, иргэний хувийн хүсэлт зэргийг үндэслэн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс шийдвэрлэнэ.

**7.**Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцоогүй Комиссын болон эмчлэгч эмчийн эмчилгээ, үйлчилгээний зөвлөмж, зааврыг удаа дараа биелүүлээгүй Нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдаагүй Эмчийн хяналтад ороогүй Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн бол иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах татгалзах, цуцлах шийдвэр гаргана. Иргэн (даатгуулагч)-ий биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан болон өндөр насны тэтгэвэр тогтоолгох тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг цуцална.

**Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэмжийг авах хүсэлт гаргах тохиолдолд даатгуулагч дараах бичиг баримт бүрдүүлнэ.**

**Үүнд:**

**1.**Монгол Улсын иргэний үнэмлэх

**2.**Монгол Улсын гадаад паспортын хуулбар

**3.**БНСУ-д оршин суух үнэмлэхний хуулбар

**4.**Нийгмийн даатгал төлж буй лавлагаа. Лавлагааг нийгмийн даатгалын аппликэйшнээс татаж авч баталгаажуулна.

**5.**Хөдөлмөрийн чадвараа

түр алдаж эмчлүүлснийг нотолсон БНСУ-ын эмнэлгийн байгууллагын тодорхойлолт –БНСУ дахь ХНХҮТ-ийн НДТ-аар орчуулга хийлгэсэн байх

–Хөдөлмөрийн чадвараа түр алдсанаа батлах шинжилгээний хариу, (ЭХО, рентген, томограф) зургийг хавсаргах

**6.**БНСУ дахь ХНХҮТ-ийн НДТ-ийн Даатгуулагчийн тодорхойлолт

**7.**Монгол Улсад харьяалах Эмнэлгийн байгууллагын Эмнэлгийн хуудас Эмнэлгийн хуудсыг нийгмийн даатгалын дэвтэр, БНСУ-ын эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, орчуулга, даатгуулагчийн тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсад харьяалах эмнэлгийн байгууллагаас Эмнэлэг хяналтын комиссын хурлын шийдвэрээр:

–Хөдөлмөрийн чадвараа түр алдаж, эмчлүүлсэн бол 30 хоногийн дотор олгоно.

**8.**Өргөдөл /Тэтгэмж авах банкны нэр, дансны дугаарыг тодорхой бичих/

Даатгуулагч дээрх баримт бичгүүдийг бүрдүүлж

**Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст Тэтгэмжийн байцаагчид аваачиж өгнө.**

**Утас: 7000-7794**



## ДУГААРЫН ЗОЧИН



“Нэг цэг” сэтгүүл дугаар бүртээ БНСУ дахь ХНХҮТ-өөс бэлтгэн хүргэдэг “Монгол хүний хөгжил” подкастын зочидтой хийсэн ярилцлагаа нийтэлдэг билээ. Энэ дугаарын зочноор БНСУ-д үйл ажиллагаа эрхэлдэг “Nice Mongolia World” ХК-ий захирал Д.Даваабаатар уригдсан юм. Тэрээр Солонгос улсад анх хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллаж байгаад өнөөгийн бизнесийн гараагаа эхлүүлсэн, хилийн чанадад амжилттай ажиллаж хөдөлмөрлөж буй монгол залуучуудын тод төлөөлөл билээ. Ингээд Д.Даваабаатартай мэргэжилтэн Ц.Мөнхцацралын хийсэн ярилцлагыг сонирхон уншина уу?

## Д.Даваабаатар: ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ИРЭЭД АЖЛЫН ХӨПСӨӨ ЦУГЛУУЛЖ БИЗНЕС ҮҮСГЭН БАЙГУУЛААД ХИЧЭЭЖ ЗҮТГЭЖ ЯВНА



“Монгол хүний хөгжил” подкастын гол зорилго бол Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ирээд ажил амьдралынх нь замнал өөдрөг, амжилттай яваа олон мянган залуусын төлөөллийг оролцуулж туршлага хуваалцах, бусдад амжилт, ололт, зэрэг сайхныг түгээхэд оршдог билээ.

**Ц.Мөнхцацрал:** –Та бидэнтэй ажил хөдөлмөрийн түүхээ хуваалцаач?

**Д.Даваабаатар:** –Би 2006 онд анх хөдөлмөрийн гэрээгээр буюу E-9 визээр Солонгост ирж байсан. 2011 онд “Nice Mongolia” карго гээд хоолны газар, карготой хувийн компаниа үүсгэн байгуулаад, 2015 онд “Nice Mongolia World” ХК болж өргөжин олон улсын тээвэр зууч, шуудан илгээмжийн үйл ажиллагаа явуулж байна. Хувьцаат компани болж байж олон улсад тээвэр зуучийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан. Солонгосоос Ази, Африкийн орнууд ч юмуу бүх л улс руу тээвэр хийх

боломжтой компани гэсэн кодтой болж байгаа юм. Тэр код энгийн компани дээр гарч ирдэггүй юм байна лээ.

**Ц.Мөнхцацрал:** –Нийт хэдэн ажилчид, салбартай вэ?



**Д.Даваабаатар:** –Солонгос улсад бол 20 гаруй салбартай, 30 гаруй ажилчидтай, Монгол дахь салбартаа 10 гаруй ажилчинтай. Одоогийн байдлаар 4 солонгос ажилтан оффист бичиг баримт дээр ажилладаг. Манай байгууллага залуусаар багаа бүрдүүлж ажилладаг онцлогтой. Хурдтай, ажлын бүтээмж өндөр байдаг санагддаг.

**Ц.Мөнхцацрал:** –Солонгост ирэхээсээ өмнө юу хийдэг байсан бэ?

**Д.Даваабаатар:** –2001 онд Өвөрхангай аймгийн Богд сумын 10 жилийн сургуулийг дүүргээд, МУИС-ийн Ойн

инженерийн ангид элсэн орж төгсөөд, их сургууль төгссөн 2005 оныхоо намар хуримаа хийгээд 2006 онд энд ирсэн байдаг юм. Тэр үед Солонгос улс тийм ч гоё хөгжсөн улс биш байсан. Анх ирэхэд мэдээж хэцүү зүйл зөндөө. 6 жил нэг үйлдвэртээ тогтвортой ажилласан. Интернет сайн хөгжөөгүй, таксфоноор ярина. Эхлээд Монголоос ирэхэд хоол ундны тал дээр дасаж зохицохгүй байхаас

эхлээд хэцүү зүйлүүд гарсан. 14-үүлээ нэг үйлдвэрт ирж байсан. Цагдаа, бөх гээд олон янзын хүмүүс, арван дөрвөн аавын хүү янз янзын ааш араншинтай, би тэр дундаа хамгийн бага нь байсан. Элдэв ааш, асуудал гарна аа. Чи залуугаараа хоол хий гэдэг ч юмуу. “Би хийх үедээ хийнэ, гэхдээ бүгдээрээ ажил хийх гэж ирсэн учраас цэрэгт байгаа юм шиг байхгүй шүү” гэдгээ хэлчихнэ ээ, бас хэхэ. Өмнөөс нь сөргөлдөж, хэрүүл маргаан хийдэггүй байсан. Би ажлын байраа солиогүй, солих юм бол дахиад бүх юмыг шинээр эхлэх учраас хүмүүс юу ч гэж хэлж байсан тэр бүхэнд авталгүй 6 жил нэг үйлдвэртээ ажилласан. 14 залуугаас 2 залуу л үлдэж байсан. Хамт үлдсэн залуу маань одоо манай компанид ажиллаж байгаа, 15 жил хамт байна даа. Ажлын байраа их сольдог хүмүүс байдаг. Цалин бага гэдэг ч юмуу, зарим нь үнэхээр ажлын байрны дарамтаас болдог байх. Зарим нь бага

Үргэлжлэл нь 38-р нүүрт



Эхлэл нь 37-р нүүрт



зэрэг асуудлыг тэвчиж чадахгүйгээс болоод ажлаа сольдог юм шиг. Гэхдээ хүчээр Солонгос улсад авчирсан биш, бүгд л өөрийн амьдрал ахуйгаа сайжруулахын тулд хувь хүний зорилготой ирж байгаа. Ирэнгүүтээ нялцгай зан гаргадаг хүмүүс бас байдаг. Тухайн газраасаа цалинг нь авч байгаа бол тэр хүндээ зүтгээд л цалингаа авах хэрэгтэй. Энэ бол миний бодол. Би нэг ч юмыг халтуурдаад, буруу зөрүү хийгээд яаж ийгээд өнгөрүүлчих юм сан гэсэн бодол байдаггүй. Энэ хүнд би ажлыг нь сайн хийж өгч байж, энэ хүн цаашаа үнэлгээ авч байж надад цалин өгч байгаа гэсэн бодол толгойд байдаг. Манай залуучууд ч гэсэн ийм бодолтой байх хэрэгтэй болов уу. Би ч монгол залуустаа хэлдэг. “Бүх юмыг сайхан цэгцтэй сураад, ажилдаа дотор нь орж ажиллах хэрэгтэй, хүний юмыг хийж байгаагаар хандах юм бол өөрсдөө ч хөгжихгүй, энэ компани ч хөгжихгүй” гэж хэлдэг юм.

**Ц.Мөнхцацрал: –Анх ирж байхдаа ямар хүсэл тэмүүлэлтэй байсан бэ, яг одоогийн энэ байдлыг зорилго болгож байв уу?**

**Д.Даваабаатар:** –Тухайн үеийн бодол үнэхээр их жижигхэн байсан юм билээ. Одоо бодоход инээд хүрдэг юм. Жижигхэн мөрөөдөлтэй байжээ. Амьдралаа дээшлүүлнэ гээд л... 3 дугаар курсдээ сурч байхдаа Өвөрхангай–Улаанбаатар хооронд хүн тээвэрт явдаг байсан, тэгээд Солонгост очих юм бол нэг сайхан Истана ч юмуу Микро машин авчраад хот хооронд явж эхнэр, хүүхдээ тэжээнэ гэсэн бодолтой ирсэн. 6 сар ажиллаад мөрөөдлийнхөө машиныг аваад Монгол руу явуулж байж билээ.

**Ц.Мөнхцацрал: Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаад яаж үргэлжлүүлээд Солонгос улсад үлдэв? Ямар виз рүү шилжүүлсэн бэ?**

**Д.Даваабаатар:** –2006 онд ирээд 2008 оноос эхлээд Монголд байсан зээлээ төлж дуусгаад мөрөөдлийнхөө машиныг аваад явуулсан хүн чинь тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болсон. Байр хоол цанаасаа өөр зарлага байхгүй юм чинь цалингаараа машин аваад явуулахаар Монголд очоод зарахаар мөнгө нь нэг нугараад байсан. Өөрөөр хэлбэл, хуучин машины бизнес хийгээд,

Инчаноос машинаа ачихдаа хажуугаар нь дугуй зэрэг бараа хийж явуулаад боломжийн болохоор нь 2 жил үргэлжлүүлсэн. Тэгээд машин явуулахад хажуугаар нь зай гараад байгаа болохоор хүмүүсээс карго аваад явуулж болно шүү дээ гэж бодоод портер худалдаж аваад 600 монгол залуус ажиллаж байсан усан онгоцны үйлдвэртэй ойр

Манай ажилчид харьцангуй тогтвортой, удаан ажиллаж байгаа. Анх Инчонд ирээд байхад нэг эмэгтэй ирээд танай энэ хавийн каргог хариуцдаг хүн больё гэхэд “Эмэгтэй хүн ядрахгүй юу, зүгээр үү?” гэхэд “Чадна аа” гээд ажиллаж эхэлсэн. Тэр хүн маань одоо долоо хоногт 2–3 удаа портер машин унаад, ачаа буулгаад маш сайн ажиллаж байгаа. Манай



газарт агуулах түрээслээд хүмүүсийн хаясан матрас зэргийг эхнэртэйгээ хамт явж авчран ангилж тавиад хүмүүст үзүүлнэ. Хүмүүс ажлаа тарж ирээд харна. Хүмүүст үүнийгээ үнэгүй өгөх ба зөвхөн боолт, каргоныхоо мөнгийг л авна. Эхнэрийнхээ нэр дээр монгол хоолны газар нээгээд “Nice Mongolia” хоолны газар ажиллуулж, эхнэр тогоочоор, би өөрөө зөөгчөөр ажиллаж байлаа. Эхнэр хувиараа аж ахуй эрхлэгч ангиллаар виз аваад би хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусангуут дагалдан визтэй болж байсан түүхтэй. Залуучууд маань тууштай байж, эхлээд сурч боловсорч хувь хүн өөрийгөө сайн таньж мэдээд, биеэ маш сайн дайчлах хэрэгтэй. Өөртөө итгэлтэй бай. Манай компанийнхан дор хаяж 6 жил болсон хүмүүс байна.

компанид ийм мундаг гурван эмэгтэй ажиллаж байна.

**Ц.Мөнхцацрал: –Сайн удирдлагатай компани улам хөгжиж, ажилчид нь нь ур чадвараа дээшлүүлж сайн ажилладаг гэж боддог. Монгол ажилчдын визний тал дээр болон Солонгост гадаадын аж ахуйн нэгж компанийн үйл ажиллагаа эрхлэн явуулахад хүндрэлтэй асуудал хэр их гарч байна вэ?**

**Д.Даваабаатар:** –Шаардлагатай бичиг баримтаа сайн бүрдүүлээд өгөхөд Солонгос талдаа ямар ч дарамт, хүндрэл байдаггүй. Шалгах цаг бол байна. Сая манайх “Зөв аарц” оруулж ирэхэд материалыг нь сайн бүрдүүлж өгөхөд 2–3 сар орчим шалгаад зөвшөөрсөн.

**Ц.Мөнхцацрал:** –Амжилттай яваа эр хүний ар талд гэр бүл, хань ижил нь зогсож байдаг. Гэр бүлээ танилцуулаач?

**Д.Даваабаатар:** –Манай эхнэр Дорнод аймгийн уугуул. Бид хоёр их сургуулиа нэг ангид төгссөн. Хоёулаа ойн инженерийн мэргэжилтэй. Хоёр хүүтэй, том хүү 17, бага хүү 3 настай. Том хүү Монголд байдаг боловч одоо энд ирээд онлайн аар хичээлээ сураад байж байна. Бага хүү энд цэцэрлэгт явдаг. Том хүүгээ цаашдаа Солонгост их сургуульд сургана гэсэн санаа байна. Аав, ээж маань Өвөрхангай аймгийн уугуул, одоо Улаанбаатар хотод амьдарч байгаа. Хадам аав, ээж ч бас хотод амьдарч байна даа.

**Ц.Мөнхцацрал:** –Энэ их ажлынхаа хажуугаар сайн хань, сайн аав байх амаргүй. Гэр бүлдээ гаргах цаг завьг хэрхэн бий болгож байна вэ?

**Д.Даваабаатар:** –Амралт их багатай, Солонгосын улаантай өдрүүдэд амрахдаа бусдын л адил кино үзэх, аялах зугаалах гээд л өнгөрөөнө дөө.

**Ц.Мөнхцацрал:** –Ажлынхаа хажуугаар урлаг соёлынхны Солонгост хийдэг тоглолтуудад дэм үзүүлэх, хүнд өвчтэй хүмүүст туслах, хандив өргөх, нутаг орон руугаа хандсан олон ажлууд санаачлан хэрэгжүүлэх гээд сайн үйлс их хийдэг юм билээ. Энэ талаар сонирхмоор санагдлаа?

**–Д.Даваабаатар:**  
–Боломжоороо хандив тусламж өгөхийг боддог. Хэдэн жилийн өмнө сумандаа түргэний тэрэг авч

өгч байсан. Богд сум маань аймгийн төвөөсөө 210 км зайтай болохоор түргэний тэрэг их хэрэгтэй гэж бодож байсан. Солонгосын Азийн аваргын тэмцээнд оролцож буй Монголынхоо паралимпийн тамирчдад тэрэг өгөх, дугуйн зардлыг даах зэргээр өөрийнхөө боломжоор сайн үйлсийн аянд оролцоод явж байгаа. Сүүлд хүүхэд залуучууд маань аймаг, улс, дэлхийд гараасай гэсэн сэтгэлээр сумынхаа шинэ сургуульд бөхийн дэвжээ авч өглөө.

**/"Монгол хүний хөгжил" подкастын 5 дахь дугаарт БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ХНХ-ын сайд А.Ариунзаяа нар оролцож БНСУ-д үйл ажиллагаа эрхлэн олон монгол залуусыг ажлын байраар хангаж, амжилттай**



ажиллаж буй Д.Даваабаатарт “Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан” цол тэмдгийг цахимаар гардуулсан билээ/

**БНСУ дахь ХНХҮТ-ийн дарга Д.Баярмандах:** –Бид подкастынхаа эхний хоёр дугаарт хөдөлмөрийн гэрээгээс ур чадвартай ажиллах хүчний виз рүү



орсон иргэд, 3 дахь дугаартаа хөдөлмөрийн гэрээгээр ирээд байх хугацаандаа спорт бодибилдингийн чиглэлээр амжилт үзүүлж яваа залуус, 4 дэх дугаартаа урлаг, спорт гээд бүхий л талаар өөрийгөө хөгжүүлж байгаа гэрээт иргэдээ урьж оролцуулаад байна. Энэ удааг хөрөнгө оруулагч, бүтээлч, хөдөлмөрч залууг урьж оролцуулж байгаагаараа онцлог билээ. Гэр бүл, хамт олон, хийж буй ажилтай нь танилцсан. Их цэгцтэй, чамбай

энэ дугаарт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Монгол Улсаас цахимаар оролцож байна. Ингээд сайдтай холбогдцгооё.

Сайн байна уу, сайд аа? Бид ХНХЯ-аас гаргасан чиг үүргийнхээ дагуу үүрэгт ажлаа явуулаад байж байна. Манай төвийн “Монгол хүний хөгжил” подкастын энэ дугаарт “Nice Mongolia World” компанийн захирал Д.Даваабаатар оролцож байна. Анх хөдөлмөрийн гэрээгээр ирээд одоо нийт 40 гаруй хүнийг ажлын байраар хангах болтлоо өсөж дэвшсэн ийм залуу байна.

**–ХНХ-ын сайд А.Ариунзаяа:**

–Сайн байцаана уу? Олон улсын тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхэлдэг гэхээр мундаг байна. Манай монголчууд, гадагшаа хөдөлмөр эрхлэхээр явж байгаа хүмүүс маань зөвхөн өөрсдийгөө болгоод өнгөрөхгүй цалин хөлснөөсөө цуглуулаад Монгол Улсад байгаа ар гэрийнхэндээ илгээж олон хүнийг тэжээж, тусалж байна. Тэр нь Монгол Улсын эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр оролцоотой байдаг. Солонгос улсыг зорьж ажиллахаар очсон монголчуудаас хөлөө олоод, өөрөө компани

хөдөлмөрлөж урагшилж хөгжсөн байна?

**Д.Даваабаатар:** –Анх Улсанд ирж байсан. Дараа нь Инчонд очоод сайн дасахгүй байсан, эхнэртээ эргээд Улсан руугаа явья гэсэн чинь “Болно гээд явсан юм чинь болох л хэрэгтэй шүү” гэснээр тэндээ төвхнөсөн дөө.

**Д.Баярмандах:** Манай



# 전북은행



## JB САНХҮҮГИЙН ТӨВ, ЖОНБҮГ БАНК

**JB BANK НЬ** 1969 ОНЫ 12 САРЫН 10 НД БАЙГУУЛАГДСАН БӨГӨӨД ТӨВ ОФФИСОО ЖОЛЛАБУГДУ ЖОНЖҮД БАЙГУУЛСАН. 2019 ОНЫ 12 САРЫН 10 НЫ ӨДӨР JB BANK НЬ 50 ДАХЬ ЖИЛИЙН ОЙГОО УГТСАН ТЭМДЭГЛЭЛТ ӨДӨР БАЙСАН. ӨНГӨРСӨН 52 ЖИЛИЙН ХУГАЦААНД ЖОНБҮГ БАНК НЬ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙНХЭЭ ТӨЛӨӨ ҮРГЭЛЖ ЧАДАХ ЧИНЭЭГЭЭРЭЭ АЖИЛЛАЖ ИРСЭН.

СОЛОНГОС ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭЭС ГАДНА **E-7, E-9, F-2, F-5, F-6** ВИЗЭЭР СОЛОНГОСТ ОРШИН СУУЖ БАЙГАА ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХИЙН ТУЛД ЧАРМАЙН АЖИЛЛАЖ БАЙГАА.

**ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН САНХҮҮГИЙН ТӨВИЙН БАЙРЛАХ ХАЯГ:**

경기도 수원시 팔달구 매산로 37 5층(코스모수원빌딩)

Холбоо барих утас: 010-2310-1901

Эхлэл нь 39-р нүүрт



байгуулаад, Солонгос улсад хөрөнгө оруулагчаар оршин сууж байгаад баяртай байна. Ийм залуус өөрсдийгөө хөгжүүлж, сурч мэдсэн ноу хаугаа Монголдоо нэвтрүүлээд, Монгол Улсаа ч гэсэн хөгжүүлнэ. Монголд үйлдвэрлэсэн Монголынхоо бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээл рүү гаргах нь чухал байна. Солонгос дахь Төв маань иргэдийнхээ хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын

**Д.Даваабаатар:** –“Тесо” группын “Зөв аарц” –ыг өнгөрсөн өвөл манай компани албан ёсоор Солонгост оруулж ирсэн. Солонгост интернэт худалдаагаар зарагдаж байгаа. Солонгост байгаа бүх монгол дэлгүүр, хоолны газруудаар зарагдаж, хүмүүс ам сайтай байгаа. Бид бас монгол гэрээ оруулж ирж байна.

**А.Ариунзаяа:** –Сайн байна. Манайхан монгол гэрээ улам сайжруулаад л байна лээ. Бусад улс орнууд манай өв соёлыг өөртөө шингээж аваад ашиглаад байхад монголчууд өөрсдийнхөө бүтээгдэхүүнийг дэлхийд гаргах нь их чухал байна аа. Энэ тал дээр та бүхэн ажиллаж эхэлсэнд баяртай байна. Цаашид илүү их хичээнгүйлэн ажиллаарай гэж хүсч



байна. Ингээд шагналыг нь цахимаар гардуулж өгье.

**Д.Даваабаатар:** –За, маш их баярлалаа. Бидний ажил, зүтгэлийг өндрөөр үнэлж байгаад их баяртай байна.

**Д.Баярмандах:** –Сайд хоёр дахь удаагаа онлайнаар шагнал гардуулж байна, өмнө нь миний шагналыг гардуулж байсан билээ. Цахимаар шагналаа авсан тэр үйл явдал миний амьдралын

баглаа цэцэг өргөн барья. Цаг заваа гаргасан сайддаа маш их баярлалаа.

**А.Ариунзаяа:** –Та бүхний ажилд өндөр амжилт хүсье. Солонгост байгаа бүх монголчуудынхаа амар мэндийг эрж, Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулдагт нь талархлаа илэрхийлж байна.

**Д.Баярмандах:** –Баярлалаа,



асуудалд дэмжлэг үзүүлж ажиллахаас гадна энд байгаа бизнесүүдийг Солонгосын зах зээл рүү гаргах тал дээр гарц хайж, анхаарвал манай компаниуд дэлхийн компаниуд болох тэр боломж нь бас бүрдэх юм шүү.

**Д.Баярмандах:** –За, цаашдаа бид тэгж ажиллана аа.

байна. Даваабаатарыг манай БНСУ дахь ХНХҮТ-өөс шагналд тодорхойлж материалыг нь ирүүлсэн. Хөдөлмөрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, салбарын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлээд ХНХ-ын сайдын тушаалаар “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” гэсэн цол тэмдгээр шагнаж



хэзээ ч мартагдахааргүй гоё агшин байсан. Энэ удаад манай хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, монгол залуусаа манлайлж яваа Д.Даваабаатар захиралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, ХНХ-ын сайд А.Ариунзаяа “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг гардууллаа. Баяр хүргэе. Сайдын өмнөөс

танд бас ажлын амжилт хүсье. Ингээд зочинтойгоо ярилцлагаа үргэлжлүүлье. Бид Д.Даваабаатарын компанийн үйл ажиллагаатай очиж танилцах үеэр нэг юм анзаарагдсан л даа. Хөрөнгө оруулж байгаа, бизнес хийж байгаа, ямарваа ажлыг явуулж байгаа хүмүүст ажлын эмх цэгц, төлөвлөлт, хувийн зохион байгуулалт





## JB САНХҮҮГИЙН ТӨВ, ЖОНБҮГ БАНК

### ЗЭЭЛ

---

**Зээлийн зорилт:** E9 ажилчид, E7 мэргэжлийн ажил эрхлэлт, F2 оршин суух, F5 байнгын оршин суух, F6 гэрлэлтийн цагаачлал

**Зээлийн хязгаар:** Доод тал нь 3 сая вон ~ дээд тал нь 15 сая вон

**Зээлийн хүү:** Жилд хамгийн багадаа 9.39-ээс хамгийн ихдээ 15.00% (зээлийн зэрэглэлээр ялгаатай өргөдөл гаргах)  
(Үндсэн хүү + нэмэлт хүү / Зээлийн хэмжээ 10 сая вон / 12 сарын зээлийн хугацаа)

**Суурь хүү:** Жилийн 0.81% (2-р сарын 19-ний өдрийн зээлийн хүүгийн 12 сарын хугацааг үндэслэн)

**Нэмэлт хүү:** Жилд 8.58 ~ Жилд 14.19% (зээлийн зэрэглэлээр ялгаатай өргөдөл гаргах)

**Буцаан төлөх арга:** Сар бүр үндсэн төлбөрийг тэнцүү хувааж төлөх, Зээлийн

**Завсрын төлбөр:** Үлдсэн хугацаанд зөрүүтэй (1 ~ 2%)

**Зээлийн хугацаа:** Хамгийн багадаа 5 сараас 36 сар хүртэл (Визний хугацаа 3 сарын эргэн төлөлт)

**Бүрдүүлэх бичиг баримт:**

Гадаадын иргэний бүртгэлийн хуудас, Паспорт, Төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл, Стандарт хөдөлмөрийн гэрээ

**Хэрхэн бүртгүүлэх вэ:**

Салбар дээр зочлох, Видео дуудлага хийх, Зочлох үйлчилгээ (JB GO)

---

**ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН САНХҮҮГИЙН ТӨВИЙН БАЙРЛАХ ХАЯГ:**

경기도 수원시 팔달구 매산로 37 5층(코스모수원빌딩)

Холбоо барих утас: 010-2310-1901

## ОЛОН УЛСЫН МӨНГӨН ГУЙВУУЛГА

**Хилийн чанадад автоматаар шилжүүлэг хийх:** Үлдэгдэл мөнгө шилжүүлэх, Байнгын шилжүүлэг

**Ухаалаг банк:** Үнэ төлбөргүй, Гадаад хэлийг дэмжих үйлчилгээ, Үнэгүй шилжүүлгийн хураамж

**Мөнгөн гуйвуулгын хязгаар:** Нэг удаа 10,000 доллар, жилд 50,000 ам

## ХАДГАЛАМЖ / КАРТ

**JB BRAVO KOREA Цалингийн дэвтэр:** Нүүр тулсан бус данс нээлгэх боломжтой

**Кредит карт:** Бусад банкны АТМ-д шимтгэлгүй гүйлгээ, тээврийн карт

**Зээлийн карт:** Картын тэтгэмж + 300,000 воны кредит, дараа төлбөрт тээврийн карт

**JB Smart Banking:** Хадгаламж үүсгэх, Нээлттэй банкны үйлчилгээ

**F-4**      **F-5**      **F-6**

**E-9 ВИЗТЭЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ АЖИЛ ХИЙДЭГ БҮХ ХҮМҮҮСТ МАНАЙ ҮҮД ХААЛГА НЭЭЛТЭЙ.**

 **JB BANK MONGOLIA YUMI**

**СОЛОНГОС ДАХЬ БАНКНЫ ЗЭЭЛ НАЙРСАГ ҮЙЛЧИЛГЭЭ, ТУХЛАГ ОРЧИН ТАНЫГ ХҮЛЭЭЖ БАЙНА.**



Эхлэл нь 41-р нүүрт



чухал. Компани нь сайхан, цэвэрхэн, эмх цэгцтэй, үйл ажиллагаа, шат дамжлагууд нь зохион байгуулалт сайтай байсан. Байгууллагын соёл, онцлогийнхоо талаар яривал ямар вэ?

**Д.Даваабаатар:** –Монгол хүн хэдий гадны оронд үйл ажиллагаа явуулж байгаа ч гэсэн үндсэрхэг байх хэрэгтэй юм байна гэж боддог. Би бол монгол хүн шүү гэж цаг ямагт бодож явах чухал. Хоёрдугаарт, монгол хүн бас ингэж амьдарч болдог юм аа гэдгийг харуулмаар байна шүү дээ. Монгол хүн гэхээр л юмны дор байх ёсгүй, нэг ч гэсэн юмаараа дээр байя. Солонгосын 50–55 сая хүн амын зах зээл дээр аль болох тулгуурлаж ажиллая, солонгос хүнд монголчуудаа сурталчилъя, харуулья гэсэн миний мөрөөдөл л дээ. Манай лоунж дээр очсон байх. Зөвхөн монголчууддаа гэхээс илүү гадны хүмүүст монгол хоолоороо, монгол үйлчилгээ хүргэж монгол хүн ийм юм хий, ингэж ажиллаж амьдардаг гэдгийг хараасай гэж хүсэж ажилладаг.

**Д.Баярмандах:** –Компанийнх нь үйл ажиллагаатай танилцах үеэрээ лоунж дээр нь очиж хооллосон. Монгол

нэрийн хоолуудыг үнэхээр гоё, амт чанартай хийсэн байна лээ. Биднийг хооллох үеэр солонгос хүмүүс ч их орж ирж байна билээ. Манай байгууллага 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын эрхэм зорилгын нэг нь монгол хүнийг ахисан түвшинд хүргэх, хөхиүлэн дэмжих, хөгжиж байгаа хүнийг бусад залуустаа үлгэр дуурайл болгож сурталчлан таниулах юм. Өнөөдөр ХНХЯ–ны чиг үүргийн дагуу Солонгос улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа манай төв хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон нийгмийн даатгалд хамрагдаж байгаа иргэдээ хариуцан ажиллаж, хүмүүсийнхээ эрх ашгийг хамгаалж, Монгол Улсын Засгийн газрын үйлчилгээг үзүүлэхээс гадна бизнес эрхэлж байгаа залуусынхаа бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой. Энэ нэвтрүүлгийг үзсэнээр монгол залуус үлгэр дуурайлал авч, үр дүнтэйгээр тэмүүлж хөгжиж, дээшилж явахыг зорилгоо болгох байх аа.

**Д.Даваабаатар:** –Миний дотроо бодож явадг зүйл байдаг юм. Гэрээгээр,

аяллаар гээд л Монголоос ирэхдээ зорилготой ирдэг байх. Ирээд бүгд биш л дээ, зарим залуус маань хүсэл мөрөөдлөөсөө урваж буруу зүйл рүү орох явдал байдаг. Тиймэрхүү зүйлд харамсаад байдаг юм. Ардаа аав ээж, хань ижил, үр хүүхдээ үлдээгээд гадаад оронд ирээд ажил хийнэ гэдэг тийм амархан юм биш, их хэцүү гэдгийг бүгд ойлгож байгаа. Сэтгэлийн хатгүй, тэвчээргүй байдлаасаа болоод буруу зүйлд уруу татагдах, хэрэг төвөгт орох асуудал бас их байна. Хэнэггүй байдлаасаа болж янз бүрийн асуудалд

хөгжил” цувралаараа хүргэж залуустаа үлгэр дуурайл авах сэдэл өгөхийг зорьсон маань энэ. Хоёрдугаарт, хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан гэрээ гэж бий. Анх 2004 онд хэлэлцэж тогтсон Хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог Солонгос улсын Засгийн газраас байнга үнэлж дүгнэж явдаг. Төчнөөн хүмүүс нь сайн амжилттай явж байна, төчнөөн хувь нь буцсан, төдөн хувь нь буцаагүй хууль бусаар байна гээд л... Анх хөдөлмөрийн гэрээгээр ирчихээд хууль бус болчихсон явж байна гэдэг бол ахиж дэвших биш харин



өртөж, архинд орж байна. Гэр бүл салалт их байна. Хөндлөнгөөс залуу хүний нүдээр хараад их харамсдаг. Зорилгодоо үнэнч байж урагш тэмүүлж, өөрийгөө ялж явах ёстой гэж боддог юм.

**Д.Баярмандах:** –Ийм үүднээс л бид энэ подкастаа хийгээд байгаа юм шүү дээ. Буруу замаар орж, алдаж эндэж байгаа залуус бас байна. Сайн сайхан явж байгаа залуус ч бас зөндөө байна. Солонгос улсад 40 монгол иргэнээ ажлын байраар хангаад явж байна гэхэд зарим хүн итгэхгүй байж мэднэ. Зөв замаар, зөв чиг бодолтой явах юм бол ийм амжилтанд хүрдэг юмаа гэдгийг бид “Монгол хүний

ч доошоо буусан байна гэсэн үг.

**Д.Даваабаатар:** –Өөрийгөө ялж чадахгүй байна гэсэн үг л дээ. Ажлын байраа солих хэд хэдэн шалтгаан байгаад байна. Бусад нь бас буруу мэдээлэл өгдөг. Наадах чинь цалин багатай газар байна, энд илүү цалинтай газар байгаа гэдэг ч юм уу. Гэрээгээр ажиллаад богино хугацаанд мөнгө цуглуулаад эх орондоо очъё, гадны улс орны үйлдвэрлэл, үйлчилгээний ноу хауг сураад эх орондоо хэрэгжүүлбэ гэсэн залуус зөндөө байна. Тавилга, оймс гээд жижиг дунд үйлдвэрт ажиллаж байсан залуучуудын зарим нь Монголд очоод

хэрэгжүүлээд, брэнд бүтээгээд явж байна. Бүгд л хөдөлмөрийн гэрээгээр ирж байсан залуучууд. Сая таны хэлдэг шиг зүйл надад бас хэд хэдэн удаа тохиолдож байсан. Би солонгос хүмүүст газар түрээсэлдэг. Тэгэхээр хүмүүс итгэж өгөхгүй “Чи монгол хүн байж яахаараа солонгос хүнд газар түрээслүүлдэг юм” гэдэг. Монголд солонгосчууд дороо монголчуудыг ажиллуулж болоод байхад би солонгос хүмүүсийг ажиллуулж, тэд нарт газар түрээсэлж болно шүү дээ гэж хэлдэг. Хоёрдугаарт, олон улсын тээвэр зуучийн компани нээчихлээ гэхээр энэ залуу ганцаараа яагаад ч барахгүй,

#### Д.Баярмандах:

–Хөдөлмөрийн гэрээгээр ирээд хууль бус болчихоор хэцүү зүйлүүд зөндөө үүсдэг. Өөрөөр хэлбэл, энэ улсын хууль танд үйлчлэхгүй болчихож байна гэсэн үг. Нэгдүгээрт, өөрт нь их хор уршиг, аюултай. Хоёрдугаарт, хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу ирж байгаа учраас хариуцлага алдсанаар хоёр улсын хооронд их том асуудал үүсгэж байна. Монгол Улс маань энэ улсад үнэлэгдэх үнэлэмжийн хувьд маш сөрөг нөлөө үзүүлж байна. Тийм учраас үүнийг сайн анхаарч байх хэрэгтэй, амжилттай сайн яваад, хуулийн дагуу ажиллаж

бичиг баримтын асуудлыг солонгос хүнд хариуцуулж ажилладаг. Гэрээгээр ирсэн залуучууд бид зөвхөн өөрсдийгөө бодож болохгүй, миний дараа ирэх хүмүүс зөндөө байгаа шүү гэдгийг бодож байх хэрэгтэй.

**Д.Баярмандах:** –Залуус маань үүнийг сайн ойлгож байгаа байх аа. Ер нь манай монголчуудын үнэлэмж дээшлээд л байгаа. 2004 онтой харьцуулахад их сайн болсон. Боловсрол, бизнес,

байна. Ажилсаг байна, чин сэтгэлээсээ хийж байна. Зам дагаж хөгжил гэдэг шүү дээ. Зам тээвэр сайн хөгжчихлөө. Би гольфоос гадна гар бөмбөг сонирхдог. Бүтэн сайн өдөр тоглодог. Ажлын өдөр завгүй байж байгаад тоглоход их сайхан байдаг. Залуучууд бид өглөө эрт босож, хийж байгаа ажилдаа сэтгэл зүрхээ зориулж, Солонгос улсад яах гэж ирсэн билээ гэдэг зорилгоо өглөө бүхэн бодох хэрэгтэй болов уу. Эх орон минь



ард нь хятад юмуу солонгос нөхөр байгаа гэж боддог. Хамтарч байгаа бол мэдээж үнэнээ хэлнэ шүү дээ. Миний хувьд гэрээний ажлаар ирээд хийсэн хөдөлмөрийн хөлсөө цуглуулаад бизнес үүсгэн байгуулаад хичээж зүтгэж явна даа. Гэхдээ би ганцаараа биш, манай хамт олон, хань ижил, олон сайхан хүмүүсийн оролцоотойгоор олон улсын тээвэр зуучийн компани маань өдий зэрэгт хүрч, олон түмний итгэлийг аваад явж байна. Улам цаашаа өргөжүүлнэ гэсэн бодолтой яваа.

амьдарч байгаа хүмүүсийн өмнөөс улс орон чинь нүүр бардам байна шүү дээ. Манай улсаас хөдөлмөрийн гэрээгээр явсан иргэд танай улсад татвар төлөгч болоод явж байна гэхэд бахархмаар сайхан. Хүний нутагт бизнес эрхлэхэд хүндрэл бэрхшээл гарах уу?

**Д.Даваабаатар:** –Хэлний хувьд бэрхшээл мэдээж гарна аа. Миний хувьд хэлний сургуульд сураагүй, гэрээгээр ажиллаж байхдаа л оройдоо үг цээжлээд, амьдрал дундаас сурсан. Байгууллагын ажлаа явуулахдаа хууль журам,



шинжлэх ухаан гээд олон салбарт залуучууд ажиллаж байна. Манай байгууллагын хувьд зорьж байгаа зүйл бол Монгол Улсынхаа иргэдийн үнэлэмжийг сайжруулах, дэмжих, чадвартай байлгахад Монгол Улсын Засгийн газраас явуулж буй бодлоготой уялдуулж ажиллах, дэмжих зорилготой.

**Ц.Мөнхцацрал:** –Инчоны гольфийн талбай дээрээс ярилцлагаа үргэлжлүүлж байна. Даваабаатар аа, гольфоор хэр удаан хичээллэж байна вэ?

**Д.Даваабаатар:** –Чөлөөт цагаараа гольфоор хичээллээд 3 жил орчим болж байна. Солонгос улс бол үнэхээр нүдэн дээр тасархай хөгжиж

улам сайхан хөгжиж, эдийн засаг сайжирч, жижиг дунд үйлдвэрлэл их болж, ажлын байр олшроод ирэхээр залуус заавал Солонгост ажил хийгээд байхгүй, эх орондоо ажиллаж амьдарч эхэлнэ. Энэ миний хүсэж явдаг зүйл минь. Монгол залуучууд минь мөрөөдлөө маш богино хугацаанд биелүүлдээд эх орондоо очиж элэг бүтэн амьдраарай гэж хэлье дээ.

**Ц.Мөнхцацрал:** –Бидний урилгыг хүлээн авч, амжилт туршлага, санаа бодлоо харамгүй хуваалцсан танд их баярлалаа. Цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье!





# ТАНЫ ТАВ ТУХТАЙ, АМАР ТАЙВАН АМЬДРАХ “АЗ ЖАРГАЛЫН ТӨГӨЛ”-ИЙГ БИД ТАНД



- Бодит **2,5 га** талбайд ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай
- Бид танд сарын **1.5 хувийн хүү** төлье /Таны захиалсан байр ашиглалтад ортол таны төлсөн урьдчилгаа төлбөрт сар бүр 1.5 хувийн хүү тооцож төлье./
- Урьдчилгаа **5 сая** өгөөд гэрээ хийх боломжтой
- Компанийн **4** жилийн хугацаа, 8 хувийн зээл.
- Урьдчилгаа төлбөрт бартер оролцуулах боломжтой.

■ Үндэсний бүтээн байгуулагч “НУТГИЙН БУЯАН ГРУПП” ХХК-ийн шинэ бүтээн байгуулалтын төсөл болох “Happy residence” хотхондоо төлбөрийн гайхалтай нөхцлүүдийг Солонгос улсад байгаа монголчууддаа санал болгож байна.

- Пентхаус айлын террас ҮНЭГҮЙ.
- **710** машины дулаан зогсол **320** машины гадна зогсоол
- Орчин үеийн шилдэг технологи /автомат цоож, хөшиг, домофон систем/
- **24** цагийн камерийн хяналт, харуул хамгаалалт
- м2 үнэ 2–3 давхар – **3,500,000**
- 4–12 давхар – **3,600,000**

**A**

3 ӨРӨӨ  
2-12 ДАВХАРУУД

**70m<sup>2</sup>**

Зочны өрөө /гал тогоо/	33.00m <sup>2</sup>
Уулзалтын өрөө 1	14.57m <sup>2</sup>
Уулзалтын өрөө 2	10.42m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	4.74m <sup>2</sup>
Түдийн хэсэг	2.95m <sup>2</sup>
Тэгт (нийт талбайн 50%)	7.45m <sup>2</sup>

ЛН ЭЭЛЖ  
(А1, А2, А3 блок)

**B**

2 ӨРӨӨ  
2-11 ДАВХАРУУД

**50.5m<sup>2</sup>**

Зочны өрөө /гал тогоо/	27.11m <sup>2</sup>
Уулзалтын өрөө	12.57m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	4.15m <sup>2</sup>
Түдийн хэсэг	4.78m <sup>2</sup>
Тэгт (нийт талбайн 50%)	3.78m <sup>2</sup>

ЛН ЭЭЛЖ  
(А1, А2, А3 блок)





# НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК



**C**

3 ӨРӨӨ  
2-11 ДАВХАРУУД

**89.43m<sup>2</sup>**

Зочны өрөө (гал тогоо)	44.36m <sup>2</sup>
Утгалтын өрөө 1	18.24m <sup>2</sup>
Утгалтын өрөө 2	13.24m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	6.25m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	4.42m <sup>2</sup>
Үүдний хэсэг	3.97m <sup>2</sup>
Тагт (нийт талбайн 50%)	7.88m <sup>2</sup>

И.НЭЭЛЖ  
(А.А.А. АН БМБ)

- Бид танд чанартай, тав тухтай орчин бүхий "Happy residence" цогцолбор хотхоныг санал болгож байна. Та санаа зоволгүй ажлаа хий, бид таны өргөө гэрийг бүтээж өгье.

## АШИГЛАЛТАД ОРОХ ХУГАЦАА

I – ЭЭЛЖ 2021 ОНЫ 1 Р УЛИРАЛД

II – ЭЭЛЖ 2021 ОНЫ 3 Р УЛИРАЛД

III – ЭЭЛЖ 2022 ОНЫ 2 Р УЛИРАЛД

IV – ЭЭЛЖ 2022 ОНЫ 4 Р УЛИРАЛД

V – ЭЭЛЖ 2023 ОНЫ 2 Р УЛИРАЛД

ТУС ТУС АШИГЛАЛТАД ОРНО.



**D**

3 ӨРӨӨ  
2-11 ДАВХАРУУД

**72.42m<sup>2</sup>**

Зочны өрөө (гал тогоо)	31.87m <sup>2</sup>
Утгалтын өрөө 1	12.82m <sup>2</sup>
Утгалтын өрөө 2	13.25m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	5.17m <sup>2</sup>
Ариун цэврийн өрөө	6.09m <sup>2</sup>
Үүдний хэсэг	2.79m <sup>2</sup>
Тагт (нийт талбайн 50%)	3.26m <sup>2</sup>

И.НЭЭЛЖ  
(А.А.А. АН БМБ)

- **Төслийн байршил:** Нийслэлийн шинэ суурьшлын бүс болох ХУД 4-р хороо Арцатын аманд байрлах "#HAPPYRESIDENCE" хотхондоо БҮХ ЭЭЛЖИЙН ЗАХИАЛГА АВЧ БАЙНА.

- **Борлуулалтын алба:** +976-7777-6565, +976-89113085, +976-89081801, +976-99105368

- **Солонгос улс дахь төлөөлөгчийн газар:** Монгол таун, Төрийн банкттай байр 2 давхарт "Хишиг" каргоны байр Утас:010-5680-7606



АМРАЛТ ЧӨЛӨӨТ ЦАГ



# ЦЭЭЖЛЭЭД АВААРЫ!

안녕하세요?

Сайн байна уу?

어느 나라에서 오셨습니까?

Аль улсаас ирсэн бэ?

몽골에서 왔습니다

Монгол Улсаас ирсэн

이름이 무엇입니까?

Нэр хэн билээ?

토야입니다

Туяа гэдэг

여권하고 입국 신고서 주세요?

Паспорт болон орох хуудсаа өгөөрэй

네,여기 있습니다

Энэ байна

한국에는 무슨 일로 오셨어요?

Солонгост ямар ажлаар ирж байна?

고용허가제로 일하러 왔어요

Хөдөлмөр эрхлэхээр ирж байгаа

/학교에서 공부하려고 왔습니다

Сурахаар ирж байна/

한국에 온 적이 있습니까?

Солонгост ирж байсан уу?

아니예요, 처음 옵니다

Үгүй ээ, анх удаа ирж байна

어디에서 일하실 예정이시죠?

Хаана ажиллахаар төлөвлөсөн бэ?

가구 공장에서 일하게 됐습니다

Тавилгын үйлдвэрт ажиллах гэж байгаа

3년 계약이시네요. 여기에 손가락 대 주시고요, 이쪽에 있는  
카메라 보세요

Гурван жилийн гэрээгээр ирж байгаа юм байна.

Хурууны хээгээ энд өгөөд, энэ камер руу хараарай

마중할 사람이 왔어요?

Угтаж авах хүн байгаа юу?

네, 밖에 기다리고 있습니다

Байгаа, гадаа хүлээж байгаа

비자/사증

Виз

여권

Паспорт

유효 기간

Хүчинтэй хугацаа

급여 명세서

Цалингийн хуудас

급여 통장

Цалингийн данс

출근부

Ирцийн бүртгэл

퇴사 신고

Ажил солих мэдэгдэл

구직 신청서

3 сарын бичиг

결근

Таслах

조퇴

Чөлөө авах

휴가

Амралт

연차 수당

Ээлжийн амралтын мөнгө

식대, 식비

Хоолны мөнгө

출국예정 사실 확인서

Хилээр гарах мэдэгдэл

출국 만기 보험 /퇴직금/

Оршин суух хугацаа дуусгавар

болсны даатгал /13 дахь сарын цалин/

국민연금

Нийгмийн даатгал

건강보험

Эрүүл мэндийн даатгал

고용보험

Хөдөлмөр эрхлэлтийн даатгал

산재보험

Үйлдвэрийн ослын даатгал

갑근세 /소득세/

Орлогын албан татвар

## ҮГИЙНТААВАР

Хүүхдүүдээрээ Монголын их яруу найрагч  
Д.Нацагдоржийн шүлгээр бүтээсэн үгийн сүлжээг  
таалгаж эх хэлнийх нь яруу тансгийг мэдрүүлээрэй!



Д.Нацагдорж  
МИНИЙ НУТАГ

Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан

Хойд зүгийн чимэг болсон ойн хөвчин

Мэнэн, Шарга, Номины өргөн их

Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан

Энэ бол миний төрсөн

Монголын сайхан

## АМЬДРАЛ

## ХҮҮХДИЙН

## НҮДЭЭР



А.Хувьтөгөлдөр 11 настай

БНСУ, Сөүл хот 2021 он

## ЭХИЙН ХЭВЛИЙ ДЭХ БОЛОВСРОЛ БУЮУ УРГИЙН БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

ГЭР БҮЛ ЧӨЛӨӨТ ЦАГ



Хүүхдийн боловсрол бүх л эцэг эхийн анхаарлын төвд байдаг асуудал. Тэгвэл хүүхдийн боловсролын суурь хэзээ анх тавигддаг талаар та сонсож байсан уу?

*Нярайн тасагт дөнгөж төрөөд удаагүй нярайг усанд оруулахад таагүй мэдрэмж, өвдөлтийг тэсэлгүй чангаар уйлах нярай олон бий. Уйлах нь мэдээжийн хэрэг. Гэвч сувилагчийн гарт өөрийгөө даатган юу ч болоогүй мэт байх нярай ч олон бий. Төрөөд 24 цаг болоогүй адилхан нярай хүүхдүүдэд гарч байгаа энэхүү ялгаа нь эхийн хэвлийд байх үеэс эхлэн шийдэгддэг тухай Харвардын Их сургуулийн сэтгэл судлалын ухааны доктор Жером Каген өөрийн бичсэн “Зан авирын үүсэл” номондоо тэмдэглэжээ.*

*Тэрээр хүүхэд ямар сэтгэл хөдлөл, зан авиртай болох нь эцэг эхийн удамшлын хүчин зүйлээс гадна эхийн жирэмсэн байх үеийн сэтгэл санааны байдал, хооллолт, зан үйлтэй ч холбогддог гэсэн санааг дэвшүүлсэн юм.*

*Олон улсад хүүхдийн эхийн хэвлийд байх үеийг онцгойлон анхаарах болж, ургийн боловсрол гэж нэрийдэх болсон бөгөөд ургийн боловсрол нь ургийн бие махбод болон оюун ухааны хөгжилд эерэг, таатай нөлөө үзүүлэхийн тулд хийж буй бүхий л үйл ажиллагааг хамруулан ойлгож болох аж.*

**Ингээд энэ удаагийн нийтлэлээр ургийн боловсролын талаар товч мэдээлэл хүргэх гэж байна.**

Ургийн боловсролыг үндсэн дөрвөн шатанд хуваах бөгөөд эхний шат ураг бүрэлдэхээс өмнө, өөрөөр хэлбэл жирэмслэлтийг төлөвлөхөөс эхэлдэг байна.

**Нэг.** Хосууд хүүхэдтэй болохоор төлөвлөж байгаа бол жирэмслэлтээс дор хаяж гурван сарын өмнөөс эхлэн ялангуяа ээж өөрийн сэтгэл зүйг болон биеэ бэлдэх нь чухал.

Ургийг тээх таатай орчин бүрдүүлэхийн тулд биед хэрэгцээт эрдэс бодис, амин дэмийг хүнс тэжээлээсээ хангалттай авахыг хичээж, нярай хүүхэд арчлах, асрах болон хүүхдийн хөгжлийн онцлогтой холбоотой анхан шатны мэдэгдэхүүнийг олж авч, судлах нь төрсний дараа үүсэж болох стрессийн хүчин зүйлийг бууруулахад ихээхэн нэмэртэй.

**Хоёр.** Ураг бүрэлдсэнээс хойш эхний гурван сард жирэмсний хордлого тохиолдох бөгөөд ээжийн биед олон янзын өөрчлөлт гарах болно. Ураг 4–6 см орчим хэмжээтэй болсон байх бөгөөд ураг гурван долоо хоногтой болох үед тархины эсийн хөгжил эхэлж дотоод эрхтний хэлбэр эхний гурван сард өөрийн хэлбэрээ гүйцэд олох болно. Дээр дурдсанчлан ургийн боловсрол нь ургийн хөгжилд таатай нөлөө үзүүлэх бүх үйлийг хэлэх тул хордлоготой байх үедээ ч эх болон урагт зайлшгүй шаардагдах шим тэжээлийг хүнсээрээ дамжуулан авч байх, өлсөхгүй бага багаар идэх, аливаа зүйлд аль болох санаа зоволгүй сэтгэл санаагаа тайван байлгах нь чухал. Өдөрт 10–15 минутын турш өөр зүйлд анхаарлаа сарниулалгүй, зөвхөн хэвлийд буй хүүхэдтэйгээ ярилцах, ном уншиж өгөх, хөгжим сонсоорой. Ингэх нь ургийн тархины хөгжилд тустай.

**Гурав.** Жирэмсний дунд үе буюу 4–7 сартай болох үед ургийн тархины эс 100 тэрбум орчимд хүрэх бөгөөд 24–27 дахь долоо хоногтойгоосоо эхлэн таван мэдрэхүйгээр дамжуулан мэдрэх чадвартай болдог. Мөн тархины сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хариуцсан хэсэг эрчимтэй хөгжиж, ээжийн сэтгэл санааны байдлыг хүүхэд тэр чигээр нь мэдэрдэг болно. Энэ үед хүүхэдтэйгээ ярилцах, ном уншиж өгөх, хөгжим сонсохоос гадна хэвлийн гаднаас зөөлөн илэх байдлаар хүүхэдтэйгээ нягт харилцаа холбоо тогтоох нь хүүхдийн төрсний дараах сэтгэл зүйн тогтвортой байдал, эзэнгшилд эерэг нөлөөтэй тухай сэтгэл судлаачид онцлон тэмдэглэсээр байна. Ээж өөрийн сонсох дуртай дууг сонсож, өөрийн хийх дуртай зүйлийг хийснээр авах сэтгэл ханамжийг ч хүүхэд давхар мэдэрч байдаг. Мөн салхи, усны чимээ, шувуу жиргэх зэрэг байгалийн чимээг сонсож өгөх нь эх хүүхдэд хоёуланд нь тустай.

**Дөрөв.** Жирэмсний сүүл үе буюу 7–9 сартай болох энэ үед ургийн жин нэмэгдсэнтэй холбоотой эхийн ходоод шахагдан, дотор тавгүйрэх мэдрэмжүүд төрдөг. Эхийн биеийн жин нэмэгдэх, арьс язрах, сэвх үүсэх гэх мэт гадаад өөрчлөлттэй стресс ч тохиож болно. Мөн төрөх дөхөх үед анхлан төрөлт, давтан төрөлтөөс үл хамааран төрөхтэй холбоотой түгшүүр үүсэх нь бий. Ээжийн мэдэрч буй дээрх бүх сэтгэл санааны байдлууд хүүхдэд ч мөн дамждаг тул жирэмсний сүүл сард бясалгал хийх, агаар салхинд гарч, байгальд алхах зэргээр өөрийгөө тайван байлгахад анхаараарай. Эцэст нь ургийн хөгжлийн аль ч үед аавын оролцоо, анхаарал халамж жирэмсэн эхэд болон урагт зайлшгүй чухал гэдгийг санаж хосууд хамтдаа хичээх хэрэгтэйг бүү мартаарай.

Эцэг эхийн боловсролын зөвлөх Г.Бэртэ





ТЭД МОНГОЛЫН ТУХАЙ



## ТАЛ НУТАГТ ЭГШИГЛЭХ МОРИН ХУУРЫН АЯЛГУУ



Монгол Улсад нэн элэгтэй нэгэн эрхмийн БНСУ-ын хэвлэлд бичсэн нийтлэлүүд манай сэтгүүлийн хуудсаар орчуулагдан гарч байгаа билээ. Солонгосын Хууль зүйн яамын харьяа Хуасон хотын Гадаад иргэдийг түр хамгаалах төвийн дарга Гил Ган Мүг нь Захиргаа, удирдлагын ухааны доктор бөгөөд Монгол Улсын ОУИЗИС-ийн хууль зүйн ухааны хүндэт доктор, Монгол Улсын филармонийн Соёлын элч билээ. Тэрээр 2017–2020 онуудад Монгол Улсад суух БНСУ-ын ЭСЯ-ны Консулаар ажиллаж байсан, Монгол Улсын төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор шагнуулсан гадаадын цөөн иргэдийн нэг юм.

1990 онд Солонгос Монгол хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны хамтын ажиллагаа илүү идэвхтэй хөгжиж байна. 2015 оны эхээр хоёр улсын хооронд зорчсон иргэдийн тоо ойролцоогоор 100000 гаруй иргэд харилцан зорчсон бөгөөд дэлхийн даяар Ковид-19 цар тахал дэгдэхээс өмнө 2020 оны 1 дүгээр сарын эхээр ойролцоогоор 220000 иргэн болж 5 жилийн хугацаанд 2 дахин нэмэгдсэн байна.

Солонгос жуулчид өргөн

уудам байгалийн унаган төрх, үзэсгэлэнт газар нутгийг үзэж танилцан, аялахыг хүсдэг улс орны нэг нь Монгол улс юм. Монгол аяллын салшгүй нэг хэсэг нь Монгол үндэсний дуу бүжгийн чуулгын ардын урлагийн тоглолт гэж хэлж болно.

Мөн түүнчлэн ардын хөгжмийн аяз, ардын бүжиг, бие биелгээ, уран нугаралт гэх мэт 90 минутын туршид үргэлжлэх үндэсний тоглолт үзүүлбэрүүд дундаас Монголын үндэсний хөгжим болох морин хуурын симфони оркестрын тоглолт хамгийн үзүүштэй сайхан тоглолт нь юм.

Зүүн Европын жуулчид “Туурайн төвөргөө”, “My Father, My Hero” морин хуурын сүр хүчтэй мөртлөө өр зөөлөн сэтгэл аргадан уясгах аязанд автан биширдэг. Хятадууд

морин хуурыг өөрийн орны үндэсний бахархал, үндэсний соёл хэмээн танилцуулдаг нь Өвөр монголын өөртөө засах орон тухайн газар нутагт харьяалагддаг болохоор тэр байх. Морин хуур нь яах аргагүй Монголын үндэсний хөгжим, өв соёл мөнөөсөө мөн билээ. 2008 онд Монгол улс нь морин хуурыг Юнескогийн соёлын үнэт өвд бүртгүүлсэн.

Морин хуур нь 800 гаруй жилийн өмнөх Чингис хааны агуу түүхэн цаг үеийг эргэн харахад түүнээс бүр өмнө үүссэн нь тодорхой байдаг. Морины толгойг сийлж, адууны сүүлээр урлан хоёрхон утсанд хорвоог уясган багтаадаг гайхамшигт өв соёл юм.

Зарим морин хуурын хийцийн хувьд морины толгойг урлан сийлэхдээ доод хэсэгт нь хөх тэнгэрийг

бэлгэдэн “хүчит лууны” дүрсийг сийлсэн байдаг. Морины дээрээс луу дарж буйгаар дүрслэн байгаа нь түүхэн он цагт Чин улсын дарлалд байсан монголчуудын хүнд он цаг үеийг болон сэтгэлийн агуу их хүч зэрэг бүгдийг багтаасан байгаа нь илт.

Дэлхийн олон төрлийн үндэсний хөгжмийн зэмсгүүд дотроос хамгийн байгальд ойр, ээлтэйг нь нэрлэ гэвэл морин хуур хэмээн бардам хэлэх байх. Морин хуурын аясыг сонсвол унаган байгальд төрж өсөн нүүдэлчин уламжлалаар амьдарч буй нүүдэлчдийн аж амьдрал болон хүн төрөлхтний зовлон зүдгүүр, энэрэл хайр, эрэмгий зориг бүгд шингэсэн нь өөрийн эрхгүй мэдрэгдэж байдаг. Морин хууранд дэлхийн бусад хөгжмийн зэмсгүүдээс



илүүтэйгээр хөгжмийн анхны цагаан толгой, ая дууны айзам, хөг аялга илүү ихээр агуулагдсан байдаг.

Хоёрхон чавхдсаар хорвоог уярааж, аргадахын сацуу мөн агуу сүр хүчийг илэрхийлдэг гайхамшигт морин хууранд бичигч миний бие Монгол Улсад консулаар ажиллаж байхдаа биширч дурласан билээ. Мөн түүнчлэн морин хуур нь адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ гэх таван хошуу малын дуу авиа, сэтгэлийг хүртэл илэрхийлж чаддаг. Ботгоо голсон ингэн тэмээг аргадсан нүүдэлчин монголчууд “хөөс хөөс” хэмээн хуурын аялгуу эгшгээр уясаан тайтгаруулахад хуурын эгшгэнд уярсан ингэн тэмээ ботгоо хөхүүлэн нулимс бөмбөрүүлж байгааг харах юутай агуу, сайхнаас сайхан, сэтгэл уярам билээ.

Яг үүн шиг уудам тал нутгаар хуурын аялгуу эгшиглэн байгаа нь яг л амьд оршихуй мэт. Мал амьтад хүртэл тэрхүү эгшиг айзамд сэтгэл нь хөдөлж байхад хүмүүний сэтгэл хэрхэх нь ойлгомжтой билээ.

Орчин үеийн морин хуур хөгжмийн суут хүн болох зууны манлай, төрийн

шагналт, алдарт хуурч бол Гомбодоржийн Жамъян (1919~2008) юм. Тэрбээр Монголын хөгжмийн урлагт түүхэн гавьяатай, суут хүн бөгөөд үндэсний болон сонгодог бүтээлүүдийг морин хуураар тоглож уг хөгжмийн аялгууг дэлхийд сурталчлахад их хувь нэмрээ оруулсан. Ардын жүжигчин, төрийн шагналт Г.Жамъян нь морин хуурыг нийтэд хүртээх гол зүйл нь “нот” хэмээн үзсэн.

Тэрээр Хөгжим бүжгийн дунд сургуульд 58 жил багшилсан бөгөөд 1970 онд гар нотоор сургалт явуулдаг байжээ. Нот нь анх уламжлалт морин хуурын сургалтанд хувьсал шинэчлэл болсон. Энэ цаг хугацаанд тэрээр морин хуурын түүхэнд анхны европын хөгжим болох Р.Шуманы “Бодол” (Schumann) (Traumerei) –ыг морин хуураар хуурдсан нь хөгжмийн шинэ хувьслыг дэлхийд таниулахад томоохон хувь нэмрээ оруулсан.

Солонгос улсад ч морин хуурыг сонирхох нь ихээхэн нэмэгдсээр байна. 2011 онд “Сүүлчийн цэргийн сум” уран сайхны кинонд ИнХа их сургуульд гадаад оюутнаар суралцаж байсан

монгол оюутны “Морин хуурын эгшиг” хэмээх аялгуу шалгарсан нь Солонгосын кино түүхэнд анхны тохиолдол болсон.

K-POP од Ү Еэ Риний кинонд ч мөн морин хуурын аялгуу эгшиглэдэг бөгөөд манай үндэсний хөгжим ХэГим, морин хуурын аялгуутай хосолсон бүтээл нийтийн хүртээл болж байгаа нь сайшаалтай. Солонгос улсад гарын 5 хуруунд багтах Ким Ён Жүний тоглосон үндэсний оркестр чуулгатай хуурын найрал хөгжим хамт тоглогдсон билээ.

Өнөө үед аймаг, орон нутагт соёлын өвөө хамгаалах үйл ажиллагаа идэвхжснээр орон нутгийн засаг захиргаа тус бүрээр нийтэд хүртээмжтэй, шинэлэг төрөл, шинэлэг соёлыг танин мэдэх шаардлага хүсэлд нь нийцүүлэн хүмүүнлэг, соёл, спорт, урлаг, уран сайхны бүхий л төрлүүдээр чөлөөт цагаараа сайн дураараа сургалтанд хамрагдах хөтөлбөрийг ханган хэрэгжүүлэн ажилласаар байна.

Нийт аймаг, орон нутаг, хотын иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэдээг харвал 2021 оны

8 дугаар сарын байдлаар манай орон нутгийн засаг захиргаа болон гадаад улс орнуудтай ах дүүсийн найрамдалт харилцаа тогтоон бэхжүүлсээр ирсэн билээ. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд ах дүүсийн харилцаа хамтын ажиллагаатай 1743 байгууллага байдаг бөгөөд Солонгос, Монголын хооронд 47 салбарт орон нутгийн засаг захиргаатай хамтран гадаад харилцаагаа хөгжүүлсээр ирсэн. Найрамдалт харилцаатай хотууд үндэсний соёл урлагаараа харилцан суралцах, цахимаар болон танхимаар харилцагч улс орны үндэсний үнэт өв соёлоос суралцах нь улс орны соёл урлагийн хөгжилд төдийгүй орон нутгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаанд ч томоохон хувь нэмрээ оруулах шинэлэг ажил болох нь дамжиггүй юм. (<https://youtu.be/41ugr-jr3A1A>)

Морин хуурч, морьтойгоо хуурын чавхдсаар нэгдэн уусах сайхан аялгуугаар энэхүү бичвэрээ өндөрлөө.

**Гил Ган Мүг**  
**2021 он, Хуасон хот**



ДУГААРЫН ЗОЧИН



*“Нэг цэг” сэтгүүл энэ дугаартаа БНСУ дахь ХНХҮТ–тэй байнгын хамтын ажиллагаатай байж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон талт ажлыг хамтран хэрэгжүүлдэг Сөүл хотын Жүнбү Цагдаагийн газрын гадаад иргэдийг хариуцсан Чой Дү Мин байцаагчийн монгол иргэдэд зориулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сануулга бүхий яриаг хүргэж байна. Ярилцлагыг мэргэжилтэн Д.Үнэнбат хийлээ. Солонгост оршин суугаа монгол иргэд хууль эрхзүйн мэдлэг дутмаг, хэл мэдэхгүй байдлаасаа болж гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт өртсөн ч хэрхэн арга хэмжээ авахаа мэдэхгүй өнгөрөх тохиолдол их гардаг билээ.*

Жүнбү Цагдаагийн газрын гадаад иргэдийг хариуцсан байцаагч Чой Дү Мин: **ХУУЛЬ БУСААР ОРШИН СУУГЧИД ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ БОЛСОН БОЛ ЦАГДААД ГОМДОЛ ГАРГАХ ЭРХТЭЙ**

–Манай төвийн урилгыг хүлээн авч ярилцаж буй танд баярлалаа. Солонгос улсад хууль бусаар оршин сууж буй иргэд тус улс орны хууль эрхзүйн талаар мэдлэг дутсанаас болж гэмт хэрэгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох нь бий. Хэрэв ийм тохиолдол гарвал ямар хууль журам үйлчилдэг вэ?

–Хууль бус иргэн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд цагдаагийн газарт гомдол гаргах эрхтэй. Ийм үед цагдаагийн газраас цагаачлалын албанд албадан нутаг буцаах мэдэгдэл хийхгүй болно.

–Яагаад албадан нутаг буцаах мэдэгдэл хийдэггүй юм бэ? Шалтгаан нь юу вэ?

–Хууль бусаар оршин сууж байгаа ч гэмт хэргийн


хохирогч болсон тохиолдолд хүний эрхийг хамгаалах хууль нэн тэргүүнд тавигддаг. Тийм учраас санаа зовох зүйлгүй шууд хохирогчийн нэхэмжлэх гаргах боломжтой. Энэ нь БНСУ–д 2013 оноос хэрэгжиж байна.

–Гадаад иргэд голдуу ямар ямар гэмт хэргийн хохирогч болж байна вэ? Хамгийн түгээмэл тохиолддог гэмт хэргүүдээс дурдвал юу юу байна вэ?

–Гадаад иргэдийн хувьд хүчирхийлэлд өртөх, гэмтэл бэртэл авах, айлган сүрдүүлгэд өртөх, хүчиндүүлэх, албан шахалтанд орох, луйвардуулах, дээрэм тонуулд өртөх, авто осолд орох, бэлгийн мөлжлөг буюу хүчирхийлэл, хоригдох, айлган сүрдүүлэлтэнд автан







бэлгийн дарамтанд орох, мөн хүний наймаа зэрэг гэмт хэргийн хохирогч болох нь элбэг.

**–Гэмт хэргийн хохирогч гэж үзэхгүй тохиолдлууд гардаг уу? Тухайлбал, ямар асуудлуудыг гэмт хэргийн хохирогч гэж үздэггүй вэ?**

–Анхаарах зүйлүүд бий. Харилцан зодооноос болж өөрөө хохирогч мөртлөө бусдыг хохироосон тохиолдол хамаарахгүй. Мөн олгогдоогүй цалингийн маргаан нэхэмжлэх бол цагдаагийн газарт хамаарахгүй. Үүнийг зөвхөн хөдөлмөрийн яаманд мэдэгдэл гаргаж шийдвэрлүүлдэг. Хэрэв Солонгост оршин суугаа монгол иргэд цагдаагийн газраас гэмт хэргийн хохирогч гэж үзэхээргүй

эдгээр тохиолдлууд гарвал, мөн өөрийгөө гэмт хэргийн хохирогч болсон эсэхээ нягтлахыг хүсвэл бидэнтэй хамтран ажилладаг БНСУ–дахь ХНХҮТ–д хандан тодруулж байгаарай!

**–Иргэд цахим залилан, гэмт хэрэгт өртөх нь бий. Яагаад ийм гэмт хэргийн гаралт ихсээд байна вэ?**

–Хэт хямд үнэтэй, хуучин бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаас болгоомжилж байсан нь дээр болов уу. naver, **중고나라, 당근마켓** зэрэг интернэтээс хуучин гар утас, камер зэргийг хэт хямд үнээр зарна гэсэн зараар бусад хүнээс урьтан, яарч мөнгөө шилжүүлсэн ч бараа нь ирэхгүй залиланд өртөн хохирох нь бий. Залилуулан хохирч цагдаад мэдэгдэн

гэмт хэрэгтэнг барьж илрүүлсэн ч бодит байдалд хохирлын нөхөн төлбөрийг барагдуулах боломжгүй нөхцлүүд их үүсдэг. Тиймээс үүнд анхаарал болгоомжтой хандах нь чухал.

**–Таны хувьд нэмж анхааруулж, сэрэмжлүүлмээр зүйлүүд юу байна вэ? Манай иргэдэд зөвлөгөө өгнө үү?**

Анхаарууштай зүйл гэвэл аливаа барааг ердийн үнээс хэт доогуур үнэтэй бол юуны түрүүнд эргэлзэн, сайн нягталж, худалдан авахаас тагталзах нь зүйтэй. Мөн буцаалт, системийн алдаа гэх мэт янз бүрийн шалтаг тоочин нэмэлт мөнгө шилжүүлэхийг шаардвал 100 хувь луйвар байдаг. Зайлшгүй худалдан авах шаардлагатай бол онлайнаар мөнгө шилжүүлж хүргэлтээр

авах гэлгүй танд төвөгтэй санагдсан ч биечлэн уулзаж бараагаа шалган хүлээн авч мөнгөө төлж байх нь хохирогч болохгүй байх хамгийн сайн арга юм.

**–Чухал зөвлөгөө, санамжууд өгсөн танд их баярлалаа. Амжилт хүсье!**







## Будаг, засал чимэглэлийн ажилчны аюулгүй байдал, эрүүл ахуй (도장작업자의 안전보건)

- Битүү орчинд ажиллах (밀폐공간작업)

안전은  
권리입니다

### Эрсдлийн гол шалтгаан

(주요 위험 요인)




Химийн бодисны хордлого  
(화학물질 중독)



Амьсгал боогдох  
(질식)



Гал түймэр (화재)



### Ажлаа эхлэхийн өмнө, ажил дууссаны дараа заавал шалгаарай.


(작업 전·후, 꼭 확인하세요)

- Ажлын аюулгүйн ажиллагааны зааварчилгаа, бодисын хор хөнөөлтэй шинж чанар болон яаралтай тусламж үзүүлэх аргыг сайтар мэдэж авна.  
(작업안전수칙, 물질의 유해성과 응급처치 요령을 숙지한다.)
- Ажлын зөвшөөрөл аван, нэвтэрсэн хүмүүсийг нягтлана.  
(작업 허가를 받고, 출입자 현황을 확인한다.)
- Хорт хийн баг зэрэг амьсгалын зориулалттай хамгаалах хэрэгсэл болон хамгаалалтын нүдний шил, бээлий өмсөнө.  
(송기마스크 등 적절한 호흡용 보호구와 보안경, 보호장갑을 착용한다.)
- Хүчилтөрөгч болон шатамхай хийн хэмжээг хэмжин, агааржуулах төхөөрөмж ажиллуулна.  
(산소 및 가연성 가스 농도를 측정하고 환기장치를 가동한다.)
- Аваарын гарцыг шалгана.  
(비상통로를 확인한다.)

### Ажлын явцад дараах зүйлийг заавал сахиарай.

(작업 중, 반드시 지켜주세요)

- Нэвтрэх хаалган дээр ажлын зөвшөөрлийн бичиг болон нэвтэрсэн хүмүүсийн нэрсийг байрлуулна.  
(출입구에 작업허가서와 출입자 현황을 게시한다.)
- Ажлын явцад ч хүчил төрөгч болон шатамхай хийн хэмжээг хэмжин, агааржуулагч төхөөрөмжийг байнга ажиллуулна.  
(작업 중에도 산소 및 가연성 가스를 측정하고 계속해서 환기장치를 가동한다.)
- Ажлын байрны ойр орчныг байнга эмхэлж цэгцлэнэ.  
(수시로 작업장 주변을 정리정돈한다.)
- Галтай сав хэрэглэхийг хориглох ба зайлшгүй хэрэглэх шаардлагатай тохиолдолд урьдчилан зөвшөөрөл авна.  
(화기사용을 금지하나 부득이 사용 시, 사전 승인을 받는다.)
- Будагч төхөөрөмжийг цахилгааны саатлаас сэргийлэх үүднээс газар тавина.  
(도장기기는 정전기 방지를 위해 접지한다.)








**Аюул, ослын жишээ**  
(Зөвшөөрөх)

**Будаг, засал чимэглэлийн ажилчны аюулгүй байдал, эрүүл ахуй**  
- Битүү орчинд ажиллах  
(догдлоогчийн аюулгүй байдал - мөлдөгчид ажил)

**Агааржуулалт хэрэгтэй. (Хувиар хэрэгтэй)**







МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**10**  
2011-2021  
ЖИЛИЙН ОЙ

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа  
БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн  
хамгааллын үйлчилгээний төв байгуулагдсаны  
10 жилийн ойн мэнд хүргэе!*

